

**АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД БОДЛОГЫН БАЙНГЫН
ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**
2023 оны 05 дугаар сарын 02-ны өдөр, Мягмар гараг

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	<i>0</i>
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	<i>1-4</i>
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	<i>5-28</i>
<hr/>	
<i>1.Элчин сайд нарыг эгүүлэн татах, томилох асуудлаар зөвшилцөх тухай /Монгол Улсын Ерөнхийлөгчөөс 2023.04.27-ны өдөр өргөн мэдүүлсэн, зөвшилцөх/</i>	<i>5-10</i>
<i>2. Улсын Их Хурлын гишүүн С.Одонтуяагаас Барилга, хот байгуулалтын сайд Ц.Даваасүрэнд хандаж “Монгол Улсад баригдсан болон баригдаж байгаа орон сууц, барилга байгууламж нь газар хөдлөлтөд тэсвэртэй эсэх” талаар тавьсан асуултын хариуг сонсох</i>	<i>10-28</i>

**Монгол Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулганы
Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны
2023 оны 05 дугаар сарын 02-ны өдөр /Мягмар гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны дарга Б.Энх-Амгалан ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 16 гишүүнээс 9 гишүүн хүрэлцэн ирж, 56.2 хувийн ирцтэйгээр хуралдаан 12 цаг 00 минутад Төрийн ордны “Их Засаг” танхимд эхлэв.

Эмнэлгийн чөлөөтэй: Ц.Сэргэлэн;
Чөлөөтэй: Н.Алтанхуяг, Э.Бат-Амгалан.

Нэг. “Чиглэл өгөх тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл /Хаалттай хэлэлцэх/

Байнгын хорооны хуралдаан 12 цаг 01 минутаас хаалттай горимоор дээрх тогтоолын төслийг хэлэлцэв.

Байнгын хорооны хуралдаан 12 цаг 22 минутад нээлттэй горимд шилжин үргэлжлэв.

Хоёр. Элчин сайд нарыг эгүүлэн татах, томилох асуудлаар зөвшилцөх тухай /Монгол Улсын Ерөнхийлөгчөөс 2023.04.27-ны өдөр өргөн мэдүүлсэн, зөвшилцөх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга Я.Содбаатар, Гадаад харилцааны яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Анхбаяр, мөн яамны Төрийн захиргаа, удирдлагын газрын дэд захирал Д.Амарсайхан, Элчин сайдад нэр дэвшигч С.Золжаргал, Б.Баярсайхан, Б.Энхбат, Э.Сарантогос нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Ж.Чимгээ байлцав.

Монгол Улсаас гадаад улсад суух Элчин сайд нарыг томилох, эгүүлэн татах асуудлаар зөвшилцөх тухай Монгол Улсын Ерөнхийлөгчийн саналыг Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга Я.Содбаатар танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт гараагүй болно.

Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатар, Н.Энхболд, С.Батболд нар үг хэлэв.

Б.Энх-Амгалан: 1. Монгол Улсаас Бүгд Найрамдах Куба улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Сэсээрийн Золжаргалыг томилох саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10

Татгалзсан: 3
Бүгд: 13
76.9 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Монгол Улсаас Япон улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Банзрагчийн Баярсайханыг томилох саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 2
Бүгд: 12
83.3 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Монгол Улсаас Бүгд Найрамдах Солонгос улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Батнямын Энхбатыг томилох саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 3
Бүгд: 12
75.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Б.Бат-Эрдэнийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дэмжсэнээр тооцож, 83.3 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Монгол Улсаас Канад улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Эрдэнэцогтын Сарантогосыг томилох саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 3
Бүгд: 12
75.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Б.Бат-Эрдэнийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дэмжсэнээр тооцож, 83.3 хувийн саналаар дэмжигдлээ.

Б.Энх-Амгалан: 1.Монгол Улсаас Исламын бүгд Найрамдах Афганистан Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Отгоны Дамбийнямыг,

2.Монгол Улсаас Бүгд Найрамдах Куба Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Шагдарын Батцэцэгийг,

3.Монгол Улсаас Япон улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Дамбадаржаагийн Батжаргалыг,

4.Монгол Улсаас Бүгд Найрамдах Солонгос Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Эрдэнэцогтын Сарантогосыг,

5.Монгол Улсаас Канад Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Ядмаагийн Ариунболдыг эгүүлэн татах саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 2
Бүгд: 12
83.3 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 12 цаг 43 минутад хэлэлцэж дуусав.

Гурав.Улсын Их Хурлын гишүүн С.Одонтуяагаас Барилга, хот байгуулалтын сайд Ц.Даваасүрэнд хандаж “Монгол Улсад баригдсан болон баригдаж байгаа орон сууц, барилга байгууламж нь газар хөдлөлтөд тэсвэртэй эсэх” талаар тавьсан асуултын хариуг сонсох

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Барилга, хот байгуулалтын дэд сайд Э.Золбоо, Барилга хот, байгуулалтын яамны Барилга, инженерийн дэд бүтцийн хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Д.Гантулга, Онцгой байдлын ерөнхий газрын дэд дарга Д.Намсрай, мөн газрын Ажиллагааны удирдлагын газрын дарга Б.Мандахгэрэл, Нийслэлийн Засаг даргын Эдийн засаг, дэд бүтцийн асуудал хариуцсан нэгдүгээр орлогч Ж.Сандагсүрэн, Хотын ерөнхий архитектор буюу Хот байгуулалт, хөгжлийн газрын дарга Ц.Тулга, мөн газрын Барилга, байгууламжийн чанарын хэлтсийн дарга Н.Тамир, Хотын стандарт хяналтын газрын дарга С.Төмөрдулам, мөн газрын Барилгын стандарт, аюулгүй байдлын хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Г.Батбаатар, Нийслэлийн Газар зохион байгуулалтын албаны дарга Г.Батзориг, Шинжлэх ухааны академийн Одон орон геофизикийн хүрээлэнгийн Газар хөдлөл судлалын салбарын дарга М.Өлзийбат, мөн хүрээлэнгийн Үндэсний мэдээллийн төвийн эрхлэгч А.Мөнхсайхан нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хяналт шалгалт, үнэлгээний газрын Хяналт шалгалтын хэлтсийн ахлах зөвлөх Ч.Онончимэг, референт Ж.Монголжингоо, Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Ж.Чимгээ нар байлцав.

Улсын Их Хурлын гишүүн С.Одонтуяагаас Барилга, хот байгуулалтын сайд Ц.Даваасүрэнд хандаж “Монгол Улсад баригдсан болон баригдаж байгаа орон сууц, барилга байгууламж нь газар хөдлөлтөд тэсвэртэй эсэх” талаар тавьсан асуултын хариуг Барилга, хот байгуулалтын дэд сайд Э.Золбоо танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн С.Одонтуяа, Д.Цогтбаатар, Б.Бат-Эрдэнэ, Б.Дэлгэрсайхан, Б.Энх-Амгалан нарын тавьсан асуултад Барилга, хот байгуулалтын дэд сайд Э.Золбоо, Барилга хот, байгуулалтын яамны Барилга, инженерийн дэд бүтцийн хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Д.Гантулга, Нийслэлийн Засаг даргын Эдийн засаг, дэд бүтцийн асуудал хариуцсан нэгдүгээр орлогч Ж.Сандагсүрэн, Хотын ерөнхий архитектор буюу Хот байгуулалт, хөгжлийн газрын дарга Ц.Тулга, Одон орон геофизикийн хүрээлэнгийн Газар хөдлөл судлалын салбарын дарга М.Өлзийбат нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Б.Дэлгэрсайхан, Д.Цогтбаатар, С.Одонтуяа нар үг хэлэв.

Улсын Их Хурлын гишүүд Улсын Их Хурлын гишүүн С.Одонтуяагаас Барилга, хот байгуулалтын сайд Ц.Даваасүрэнд хандаж “Монгол Улсад баригдсан болон баригдаж байгаа орон сууц, барилга байгууламж нь газар хөдлөлтөд тэсвэртэй эсэх” талаар тавьсан асуултын хариуг сонслоо.

Байнгын хорооны хуралдаанаар 3 асуудал хэлэлцэв.

Нээлттэй хуралдаан 1 цаг 31 минут үргэлжилж, 16 гишүүнээс 13 гишүүн хүрэлцэн ирж, 81.3 хувийн ирцтэйгээр 13 цаг 53 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

АЮУЛГҮЙ БАЙДАЛ,
ГАДААД БОДЛОГЫН
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

Б.ЭНХ-АМГАЛАН

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ
ШИНЖЭЭЧ

Э.СУВД-ЭРДЭНЭ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2023 оны 05 дугаар сарын 02-ны өдөр,
Мягмар гараг
Төрийн ордон “Их Засаг” танхим
09 цаг 21 минут

АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

*Нэг.Элчин сайд нарыг эгүүлэн татах,
томилох асуудлаар зөвшилцөх тухай
/Монгол Улсын Ерөнхийлөгчөөс
2023.04.27-ны өдөр өргөн мэдүүлсэн,
зөвшилцөх/*

Б.Энх-Амгалан: Н.Анхбаяр Гадаад харилцааны яамны Төрийн нарийн бичгийн дарга, Д.Амарсайхан тус яамны Төрийн захиргаа удирдлагын газрын дэд захирал болон албаны хүмүүс ирсэн байна. Нэр дэвшигч нар бас ирсэн байна. Сэсээрийн Золжаргал Монгол Улсаас Бүгд Найрамдах Куба улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар, Банзрагчийн Баярсайхан Монгол Улсаас Япон Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар, Батнямын Энхбат Монгол Улсаас Бүгд Найрамдах Солонгос Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар, Эрдэнэцогтын Сарантогос Монгол Улсаас Канад Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар.

Монгол Улсаас гадаад улсад суух Элчин сайд нарыг томилох, эгүүлэн татах асуудлыг зөвшилцөхөөр 2023 оны 4 сарын 27-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн. Монгол Улсын Ерөнхийлөгчийн саналыг Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга Янугийн Содбаатар даргад танилцуулна. Содбаатар даргын микрофоныг өгье. 2 номерын микрофон.

Я.Содбаатар: Эрхэм хүндэт Улсын Их Хурлын Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын үндсэн хуулийн 33 дугаар зүйлийн нэг дэх хэсгийн 5 дахь заалт, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 3, Засгийн газрын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 4, Дипломат албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 1 дэх заалтыг тус тус үндэслэн Монгол Улсаас Исламын Бүгд Найрамдах Афганистан улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Отгоны Дамбийнямыг эргүүлэн татах,

2.Монгол Улсаас Бүгд Найрамдах Куба Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Шагдарын Батцэцэгийг эргүүлэн татаж, Монгол Улсаас Бүгд Найрамдах Куба Улсад суух Онц бөгөөд Бүрэн Эрхт Элчин сайдаар Сэсээрийн Золжаргалыг,

3.Монгол Улсаас Япон улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Дамбадаржаагийн Батжаргалыг эргүүлэн татаж, Монгол Улсаас Япон Улсад суух Онц бөгөөд Бүрэн Эрхт Элчин сайдаар Банзрагчийн Баярсайханыг,

4.Монгол Улсаас Бүгд Найрамдах Солонгос Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Эрдэнэцогтын Сарантогосыг эргүүлэн татаж, Монгол Улсаас Бүгд Найрамдах Солонгос Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Батнямын Энхбатыг,

5.Монгол Улсаас Канад Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн Эрхт Элчин сайд Ядмаагийн Ариунболдыг эргүүлэн татаж, Монгол Улсаас Канад Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Эрдэнэцогтын Сарантогосыг тус тус томилох саналыг оруулж байна.

Эргүүлэн татагдаж буй Элчин Дамбийням, Ариунболд, Батжаргал нарын томилолтын хугацаа дууссан. Элчин сайд Сарантогосыг ажлын шаардлагаар сэлгэн ажиллуулж байгаа, Элчин сайд Батцэцэгийн томилолтын хугацаа нь үндсэндээ дууссан тул

эргүүлэн татах саналыг танилцуулж байна.

Монгол Улсын Их Хурлын 2013 оны 43 дугаар тогтоолоор Монгол Улсаас Исламын бүгд найрамдах Афганистан улсын нийслэл Кабул хотод Элчин сайдын яамны үйл ажиллагааг сэргээж ажиллуулахаар шийдвэрлэсэн боловч Элчин сайдын яамыг нээгээгүй байгаа.

Гэхдээ тус улсад суух Элчин сайдаар Отгоны Дамбийнямыг 2014 онд томилж түүнд Иран улсыг хавсруулсан бөгөөд өнөөг хүртэл эргүүлэн татах асуудлыг эрх зүйн хувьд эцэслэн шийдвэрлэгдээгүй байсан юм. Элчин сайд нь Монгол Улсын олон улсын гэрээ холбогдох хууль тогтоомжоор олгогдсон бүрэн эрх, хүлээсэн чиг үүргийнхээ хүрээнд суугаа болон хавсран суугаа улс Олон улсын байгууллагад Монгол Улсыг төлөөлөн ажиллаж, ашиг сонирхол болон эрхийг хамгаалах, харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэх Монгол Улсын хөгжлийн зорилтуудыг шийдвэрлэгдэхэд шаардагдах судалгааг хийж, төр засгийн байгууллагыг мэдээллээр хангах, гарсан шийдвэрийг хэрэгжүүлэх, 2 болон олон талын харилцааны асуудлаар яриа хэлэлцээр хийх, гэрээ хэлэлцээр байгуулах, Монгол Улсын иргэн, хуулийн этгээдийн хууль ёсны эрх, ашиг сонирхлыг олон улсын эрх зүй суугаа орны хууль тогтоомжийн дагуу хамгаалж ажилладгаас гадна тэргүүлж буй Элчин сайдын яамныхаа үйл ажиллагааг нэгдсэн удирдлагаар хангах чиг үүрэгтэй байдаг юм.

Элчин сайдаар томилон ажиллуулахаар нэр дэвшүүлж буй эдгээр албан хаагчид төрийн алба, дипломат албад олон жил ажилласан, мэргэжлийн өндөр ур чадвартай, удирдах ажлын дадлага туршилагатай, гадаад хэлний зохих мэдлэгтэй төрийн болон дипломат албаны хууль тогтоомжийн шалгуурыг хангасан төрийн тусгай албанд ажиллах

бүрэн боломжтой албан хаагчид гэж үзэж байгааг илтгэж байна.

Монгол Улсын Ерөнхийлөгчөөс дээрх орнуудад суух Онц бөгөөд Бүрэн эрхтэй Элчин сайдад нэр дэвшиж байгаа албан хаагчдыг зөвшилцөх асуудлыг хэлэлцэн шийдвэрлэж өгнө үү.

Б.Энх-Амгалан: Содбаатар даргад баярлалаа. Зөвшилцөхөөр орж ирж байгаа хүмүүсийн танилцуулгууд гишүүдэд тарсан байгаа учраас Монгол Улсын Ерөнхийлөгчийн санал болон нэр дэвшигчдээс асуух асуулт байвал гишүүд нэрсээ өгнө үү. Асуух асуулттай гишүүд алга байна. Асуултыг тасаллаа.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн санал болон нэр дэвшигчтэй холбогдуулан үг хэлэх гишүүд нэрээ өгнө үү. Цогтбаатар гишүүнээр тасаллаа. Цогтбаатар гишүүний микрофоныг өгье.

Д.Цогтбаатар: Орж ирж байгаа хүмүүсийг би дэмжиж байгаа. Дэмжих шалтгаан юунд байгаа вэ гэхээр энэ хүмүүс бол гадаад бодлогыг бид нар эдийн засагжуулна гэж ярьдаг. Тэгэхээр тэр эдийн засагжуулах ажлыг бол хийж чадах хүмүүс гэж би мэдэж байгаа.

Энэ салбартаа бас ажиллаж байсан, энэ чиглэлээр бас нэлээн одоо ажлуудыг яг хамтраад хийж байсан хүний хувьд бол би эд нарыг мэднэ. Тэгэхээр би та хэддээ захиж нэг юм хэлмээр байгаа юм. Нээрээ гадаад бодлогыг эдийн засагжуулах тал дээрээ онцгой анхаарч ажиллах хэрэгтэй байна. Тэгэхгүй сүүлийн одоо 2 жилд бид нарын өнөөдөр энэ инфляц, эдийн засгийн хүндрэл бол яах аргагүй гадаад валютын нөөцийн хомсдол, гадаад худалдааны бууралт, огцом бууралт, гадаадын хөрөнгө оруулалтын бууралт ингээд гадаад гэсэн тодотголтой бүх юмнууд дээр уналт гарчихаар Монгол Улсын эдийн засагт, Монгол хүний амьдралд ямар хүндрэл гарч байгааг та нар харж байгаа. Тэгээд энэ дээр ингээд дуугүй

болчихсон байж болохгүй. Гадаад бодлогыг эдийн засагжуулах хөтөлбөр гэдгийг 2008 онд Батболд сайд Гадаад хэргийн сайд байхад, Баяр дарга Ерөнхий сайд байхад баталж гаргаж байсан. Тэгээд Монгол хүний амьдралтай гадаад бодлого шууд уялдаа холбоотой байх ёстой. Тэр өгөөж нь Монгол хүний амьдрал дээр очиж тусаж байх ёстой гэсэн үүднээс энийг гаргаж байсан. Тэгэхээр та нараас одоо байх ёстой хүлээлт бол энэ дээр зангидагдана. Ялангуяа Япон, Канад, Солонгос, Куба ч гэсэн бид нарын хувьд бол маш олон жилийн бас түнш, найрсаг түнш ямар ч үед зангаа хувиргаж байгаагүй ийм орнууд байгаа. Тэгэхээр энэ дээр тэр эдийн засагжуулах тал дээрээ та нар онцгой анхаарч ажиллаарай л гэж хэлмээр байна. Тэгээд амжилт хүсье.

Б.Энх-Амгалан: Цогтбаатар гишүүнд баярлалаа. Нямаагийн Энхболд гишүүний микрофоныг өгье.

Н.Энхболд: Би Ерөнхийлөгчийн саналуудыг дэмжиж байна. Энэ Золжаргал, Сарантогос 2 бол яг системдээ ажиллаж байсан. Ер нь ингээд жишээ нь Кубад очно, Канадад очно гээд эхлэхэд аль хэдийн хийх ажлууд, тэргүүлэх чиглэлүүд, эрэмбэ юмнуудаа бол би бодчихсон, мэдчихсэн байж байгаа байх гэж бодож байна. Баярсайхан, Энхбат 2-т нэг зүйл хэлье гэж бодсон юм. Энэ сүүлийн үед Орос, Японы дайнаас болоод дэлхийн геополитикийн нөхцөл байдал үндсэндээ дэлхийн шинэ дэг рүү явах энэ үйл явц хөдөлчихсөн том гүрнүүд энэтэй уялдуулаад холбоотон түнш улсуудтайгаа хамтарч явуулдаг бодлогууддаа их өөрчлөлтүүд оруулаад эхэллээ шүү дээ. Ялангуяа Солонгос, Япон 2 бол жишээ нь Америкийн хувьд онцгой чухал ач холбогдолтой, илүү их ач холбогдолтой ийм түншүүд болж эхэлж байна. Сүүлийн үеийн уулзалтуудаар ярьж байгаа зүйлүүд нь тухайлбал цөмийн зэвсгийн тухай асуудал их эрчимтэй яригдаж эхэлсэн. Аль алинтай

нь. Солонгосчууд өөрөө энэ талаар их идэвхтэй санаачилга гаргаад тэрэнд нь Америкууд Америк та нарт жаахан азнаж байгаарай, ер нь хэрэг байна уу даа бид л та нарын бамбай шүү дээ гэсэн маягаар, нөгөөдүүл нь бол арай өөр өнцгөөр юмаа хараад байгаа гэх мэтчилэн. Тэгээд энэ Япон бас ялгаа байхгүй.

Тэгээд энэ зүйлүүд яг манайтай харилцах юмнууд дээр бас ямар нэгэн байдлаар тусна. Ийм асуудлууд яриад ирвэл бид нар ямар байр суурь баримтлах вэ. Яг үнэхээр ямар түвшинд тэр 2 улс улс хоорондын Америк- Япон, Америк-Солонгос, тэгээд Солонгос-Япон 2-ын хоорондын энэ чиглэлийн асуудлуудад ямар өөрчлөлтүүд гарч байна, ямар чиг хандлага гарах нь вэ, хэн нь ямар байр суурьтай байна гэдэг ч юм уу энэ том асуудлуудад их мэргэжлийн үүднээс хандаж, суралцаж, яамтайгаа хамтарч ажиллах ийм шаардлага гарч байгаа шүү. Тэгээд энэ дээр онцгой анхаарч ажиллаарай гэж хэлэх байна.

Тэр иргэдтэйгээ ажиллах бусад зүйлүүдийн талаар бол бас өөрсдийн юмнууд байгаа байх. Тэгэхээр ялангуяа энэ өөрчлөгдөж байгаа нөхцөл байдалд юунд их ач холбогдолгүй аль мэдээлэлд илүү анхаарах вэ. Аль дүгнэлт Төв рүү өгөх юмнууд дээрээ ийм ийм онцгой нөхцөл байдлууд, онцгой байдлууд, бодлогын өөрчлөлтүүд хандлага гармаар байна гэдэг дээр их анхаарал тавьж ажиллаж байж та нарын тэнд энэ чухал улсад Элчин сайдаар очсоны хэрэг гарна. Ялангуяа Энхбат дээр бол бид нар чинь сүүлийн үед бас нөгөө талдаа санаанд оромгүй томилолтууд ингээд хийж байна шүү дээ. Нэг хүн явуулаад хүлээж аваагүй цаад талд үндсэндээ. Энхбатын хувьд бол би гайгүй байх болов уу гэж бодож байна. Хэл устай тэндээ бас ажиллаж байсан. Бас тодорхой хэмжээний хэлхээ, холбоо сүлбээтэй. Тэгэхээр за би бол зүгээр энд нэг санамсаргүй ингээд томилогдоод ирчихсэн хүн биш, чадна гэж манай

Ерөнхийлөгч, манай улс итгээд явуулсан гэдгийг чадаж байна гэж хариулах хэмжээнд л ажиллах хэрэгтэй. Яам нь ч гэсэн нэгэнт томилоод явуулбал бүх талаар нь дэмжиж ажиллах хэрэгтэй. Санал өгөөд, дэмжээд явуулж байгаа Улсын Их Хурал, Байнгын хороо ч гэсэн нэгэнт явуулж байгаа бол тэгээд араас нь бүхий л талаар дэмжиж ажиллах шаардлагатай байгаа шүү гэдгээ бас хэлье.

Б.Энх-Амгалан: Баярлалаа. Гишүүдийн хэлж байгаа саналуудыг манай нэр дэвшигч нар бичиж, тэмдэглэж аваарай. Тэгээд ажилдаа сайн чиглэл болгож явна биз дээ. Монгол Улсын Ерөнхийлөгчөөс зөвшилцөхөөр ирүүлсэн Монгол Улсаас гадаад улсад суух зарим Элчин сайд нарыг томилох асуудлаар. Та үг хэлэх гэж байна уу. Батболд гишүүний микрофоныг өгье.

С.Батболд: Би харин явцын дунд 2 санаа нэмээд хэлчихмээр бодогдоод харин микрофон авчихлаа. За юуны өмнө нэр дэвшиж байгаа Элчин сайдад нэр дэвшиж байгаа нөхдийг бол дэмжиж байгаа. Тэгээд гишүүд маань бас санал бодлоо хэлчихлээ. Ер нь зүгээр эдийн засгийг ч ярьж байна. Бусад юмнууд ярьж байна. Энэ бүгдээрээ мэдэж байгаа. Гэхдээ энэ дээр бас нэг тийм уялдуулсан юугаар нэлээн анхаарах ёстой. Гадаад харилцааны яам маань ажиллаад л байгаа гэж би ойлгож байгаа юм байгаа. Энэ визний харилцаан дээрээ ер нь бол бид нар бага багаар ахиц гаргаад л байдаг л даа. Гэхдээ энэ дээр нэг тийм нэгдсэн бас нэг ойлголт төлөвлөгөө гаргах, тэгээд үе шаттай ажиллах энэ зүйлээрээ бас нэг Байнгын хороон дээрээ нэг мэдээлэл өгөөд, тэгээд холбогдох чиглэлүүд дээр Элчин сайдын яамнуудын үйл ажиллагаа, тэр 2 талын уулзалтуудаар ахиулдаг юмнууд ялангуяа иргэдийн харилцааны талаар явах энэ ажлуудаа бас нэлээн анхаарах нь зөв байх. Ер нь бол хүлээлт нэлээн байгаад л байгаа шүү дээ. Солонгос дээр бол иргэдийн харилцаан дээр нэлээн ахиц гарч

ирж байна. Визний харилцаа дэвшилттэй болж байна гээд л жишээлбэл ярьж байгаа. Тэгээд энэ асуудлаа нэлээн тийм барьж авч урагшлуулах ёстой байх гэж бодож байна. Визний харилцаатай.

Дээр нь энэ Канадад элчин сайд маань томилогдож байгаа юм байна. Ер нь Канад бол бас манайхтай олон чиглэлээр ажиллах боломжтой. Уул уурхай, Хөдөө аж ахуй, тэгээд төрийн албаны шинэчлэл гээд өмнө 2010 билүү 2011 онд Ерөнхий сайдын түвшинд айлчлал хийж байхад бол нэлээд зүйлүүдийг яриад, дунд бөгөөд урт хугацааны ойлголт хамтран ажиллах чиглэлүүд гарч байсан. Тэгээд сүүлдээ болбол яах вэ тэгээд бас зогсчихоогүй юм шиг байгаа юм. Гэхдээ тэр суурь тавигдсан томоохон асуудлууд бол системтэй хэр явагдсан бэ гэдэг ажлыг бол бас нэг эргэж үзээд, тэгээд улс орнуудтай харилцаж байгаа харилцаандаа тэр бидний үед ярьж байсан одоо ч та нар маань яриад үргэлжлүүлж байдаг дунд бөгөөд урт хугацааны хөтөлбөрүүдээ нэлээн сайн нухацтай авч үзээд, энийгээ явж байгаа элчин сайд нар болгон ахиулах түвшинд энэ дунд хугацааны хөтөлбөр байдаг бол энийг явуулах нь зөв байх. Канадуудтай бол уг нь овоо л юмнууд ярьж байсан. Тэгээд миний ойлгож байгаагаар бид чинь нөгөө илүү дэмжлэг хүсэж байгаа. Тэгээд бидний зүгээс Монгол талаасаа гэж ярья. Тэгээд 1 цонхоор ярьдаг болохоор гадаад яамаараа дамжуулаад тохирсон зүйлүүд авах, хамтрах зүйлүүдээ бол нэлээн санаачилга нь манай талдаа илүү байх ёстой байх гэж, анхаарах ёстой байх гэж тэгж бодож байна.

Тэгээд Японы хувьд бол Эдийн засгийн түншлэлийн хэлэлцээ гэж байгуулаад 2012 оны айлчлалаар бол санамж бичиг байгуулж, тэгээд нэлээн хэдэн жил ярьж байгаад энэ түншлэлийн хэлэлцээр байгуулсан байх. Тэгээд яг үүний үр дүн маань уг нь нэлээн том

нэртэй л ийм юу байгуулагдсан. Яаж явж байгаа юм, яаж дүгнэж байгаа юм цааш нь яах ёстой гэж байгаа юм гээд энэ зүйлүүдээ бас нэг бодож боловсруулах ёстой байх гэж бодож байна. Тэгээд эдгээр зүйлүүдээ анхаарна биз. Ер нь сая тогтоолоор чиглэл өгөгдчихсөн, Байнгын хороон дээр бас 3 дугаар улиралд гадаад харилцааны чиглэлээр байгаа нэлээдгүй асуудлаар бас дүгнэж ярина гэж байгаа юм байна. Тэгээд энэ үеэр бол Гадаад яам бас өнөөдөр яригдсан асуудлууд, өмнө яригдаж байсан асуудлуудаа ер нь чиглэл чиглэлээр нь гадаад бодлогын үндсэн.../минут дуусав/

Б.Энх-Амгалан: Батболд даргад 1 минут нэмээд өгчихье.

С.Батболд: Эдийн засгийн энэ хамтын ажиллагаа, худалдаа, хөрөнгө оруулалт дээр нь иргэдийн харилцаа, визийн харилцаа тэгээд улс орнуудтай явж байгаа тэр дунд бөгөөд дунд хугацааны хөтөлбөрүүд байдаг бол энэ мэт ажлууд маань ямар явж байна төрийн зүгээс ямар дэмжлэг хэрэгтэй байх юм. Энэ тал дээрээ бас нэлээн дүгнэсэн юмнууд оруулж ирж ярих нь зүйтэй байх гэж бодож байна аа тэгээд нэр дэвшигчдээ бүгдэд нь амжилт хүсье.

Б.Энх-Амгалан: Баярлалаа. Гишүүд үг хэлж дууслаа. Одоо санал хураалт явуулна.

Монгол Улсын Ерөнхийлөгчөөс зөвшилцөхөөр ирүүлсэн Монгол Улсаас гадаад улсад суух зарим Элчин сайд нарыг томилох асуудлаар санал хураалт явуулъя. Дэгээрээ хүн бүр дээр явуулах ёстой.

1.Монгол Улсаас Бүгд Найрамдах Куба улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Сэсээрийн Золжаргалыг томилох саналыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Гишүүд ээ, санал хураалт. Санал хураалтад 13 гишүүн оролцож, 10

гишүүн дэмжиж, 76.9 хувийн саналаар уг санал дэмжигдлээ.

2.Монгол Улсаас Япон улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Банзрагчийн Баярсайханыг томилох саналыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал санал хураалт гишүүд ээ. Санал хураалтад 12 гишүүн оролцож, 10 гишүүн дэмжиж, 83.3 хувийн саналаар уг санал дэмжигдлээ.

3.Монгол Улсаас Бүгд Найрамдах Солонгос улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Батнямын Энхбатыг томилох саналыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. Санал хураалтад 12 гишүүн оролцож, 9 гишүүн дэмжиж, 75 хувийн саналаар санал дэмжигдлээ. Бат-Эрдэнэ гишүүний саналыг протоколд үлдээгээд авчхаарай. Сая төхөөрөмж нь ажиллаагүй байна. 75 хувийн саналаар уг санал дэмжигдлээ.

4.Монгол Улсаас Канад улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Эрдэнэцогтын Сарантогосыг томилох саналыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. Санал хураалтад 12 гишүүн оролцож, 9 гишүүн дэмжиж 75 хувийн саналаар уг санал дэмжигдлээ. Бадмаанямбуугийн Бат-Эрдэнэ гишүүний саналыг дэмжсэнээр протоколд тусгаарай.

Монгол Улсаас гадаад улсад суух зарим элчин сайд нарыг томилох асуудлаар санал хураалт явуулж дууслаа.

Монгол Улсаас улсаас гадаад улсад суугаа зарим Элчин сайд нарыг эгүүлэн татах асуудлаар санал хураалт явуулна.

Монгол Улсаас Исламын бүгд Найрамдах Афганистан Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Отгоны Дамбийнямыг,

Монгол Улсаас Бүгд Найрамдах Куба Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Шагдарын Батцэцэгийг,

Монгол Улсаас Япон улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Дамбадаржаагийн Батжаргалыг,

Монгол Улсаас Бүгд Найрамдах Солонгос Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Эрдэнэцогтын Сарантогосыг,

Монгол Улсаас Канад Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Ядмаагийн Ариунболд нарыг эгүүлэн татах саналыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Саналаа өгнө үү гишүүд ээ. Санал хураалт. Санал хураалтад 12 гишүүн оролцож, 10 гишүүн дэмжиж, 83.3 хувийн саналаар уг санал дэмжигдлээ.

Монгол Улсаас гадаад улсад суугаа Элчин сайд нарыг эгүүлэн татах асуудлаар санал хураалт явуулж дууслаа.

Монгол Улсаас гадаад улсад суух Элчин сайд нарыг томилох, эгүүлэн татах асуудлыг зөвшилцөх тухай Монгол Улсын Ерөнхийлөгчийн саналыг хэлэлцэж дууслаа.

Байнгын хорооны санал дүгнэлтийг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд Нямаагийн Энхболд гишүүн танилцуулъя. Баярлалаа. Ажлын хэсэгт, Сайд нартаа амжилт хүсье.

12.43 цаг.

Дараагийн асуудалд оръё. Ажлын хэсгээ оруулъя.

Хоёр. Улсын Их Хурлын гишүүн С.Одонтуяагаас Барилга, хот байгуулалтын сайд Ц.Даваасүрэнд хандаж “Монгол Улсад баригдсан болон баригдаж байгаа орон сууц, барилга байгууламж нь газар хөдлөлтөд тэсвэртэй эсэх” талаар тавьсан асуултын хариуг сонсох

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 111 дүгээр зүйлд гишүүн асуултын хариуг Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцүүлэх саналаа Байнгын хорооны даргад бичгээр ирүүлсэн бол Байнгын хорооны дарга асуултын хариуг хэлэлцэх товыг гишүүний саналыг харгалзан зөвлөл танилцуулж шийдвэрлэхээр заасны дагуу өнөөдрийн Байнгын хорооны хуралдаанаар уг асуудал хэлэлцүүлэхээр хуралдааны тов дараалалд орсон байна. Ажлын хэсгийн гишүүдийг танилцуулъя. Э.Золбоо Барилга, хот байгуулалтын дэд сайд, Д.Гантулга мөн яамны Барилга, инженерийн дэд бүтцийн хэрэгжилтийн зохицуулах газрын дарга, Д.Намсрайн Онцгой байдлын ерөнхий газрын дэд дарга, Б.Мандахгэрэл Онцгой байдлын ерөнхий газрын Ажиллагааны удирдлагын газрын дарга, Онцгой байдлынхныг дуудаарай Мөнгөнчавхдас аа, Д.Баян-Эрдэнэ Онцгой байдлын ерөнхий газрын Гал түймрийн улсын хяналтын хэлтсийн дарга, Ж.Дамдинсүрэн Онцгой байдлын ерөнхий газрын Дэд бүтэц, газар хөдлөлтийн тасгийн дарга, Ж.Сандагсүрэн Нийслэлийн Засаг даргын Эдийн засаг, дэд бүтцийн асуудал хариуцсан 1 дүгээр орлогч, Ц.Тулга Хотын Ерөнхий архитектур бөгөөд Хот байгуулалт, хөгжлийн газрын дарга, С.Төмөрдулам Хотын Стандарт хяналтын газрын дарга, Г.Батбаатар Хотын Стандарт хяналтын газрын Барилгын стандарт, аюулгүй байдлын хэлтсийн даргын албыг албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Н.Тамир Хот байгуулалт, хөгжлийн газрын Барилга, байгууламжийн чанарын хэлтсийн дарга, Г.Батзориг Нийслэлийн газар зохион байгуулалтын албаны дарга, Б.Загдсамбар Нийслэлийн газар зохион байгуулалтын албаны Кадастрын хэлтсийн дарга, М.Өлзийбат Шинжлэх ухааны академийн Одон орон геофизикийн хүрээлэнгийн Газар хөдлөлт судлалын салбарын дарга, А.Мөнхсайхан Шинжлэх ухааны академийн Одон орон геофизикийн хүрээлэнгийн Үндэсний

мэдээллийн төвийн эрхлэгч. Ажлын хэсгийг танилцуулж дууслаа.

Одоо Барилга, хот байгуулалтын сайдын мэдээллийг Барилга, хот байгуулалтын дэд сайд Энхтүвшиний Золбоо танилцуулна. Золбоо сайдын микрофоныг өгье. 3 номерын микрофон.

Э.Золбоо: Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэж байна.

Монгол Улсад байгаа барилга, байгууламжууд газар хөдлөлтөд тэсвэртэй эсэх талаар мэдээлэл өгье. Ялангуяа 2023 оны 2 дугаар сарын 28-ны өдөр Улсын Их Хурлын гишүүн, дэд дарга Одонтуяа Барилга, хот байгуулалтын сайд Даваасүрэнгээс 4 асуулт бүхий асуулгыг асуусан. Тэгээд энэ асуултуудад хариулах хэлбэрээр холбогдох мэдээллүүдийг давхар өгөөд явъя.

1 дүгээр асуулт бол өнөөдөр байгаа барилга байгууламжуудын нөхцөл байдал ямар байгаа вэ. Газар хөдлөлтөд тэсвэртэй эсэх талаар байришил байришлар нь мэдээлэл өгөөч гэдэг агуулга бүхий асуулт асуусан байна. Үүнд хариулахад, аливаа барилга, байгууламжууд газар хөдлөлтөд тэсвэртэй байдлаар баригдахад хамгийн чухал зүйл бол бичил мужлалын зураглал байдаг. Бичил мужлалын зураглал хийгдэж байж тухайн байришлын баллыг тодорхойлж гаргаж ирдэг. Энэ хүрээндээ Монгол Улсын хувьд бид бүхэн 21 аймгийн 12 аймаг дээр нь бол бичил мужлалын зураглалыг хийсэн. Улаанбаатар хотын 9 дүүрэгт мөн бичил мужлалын зураглалыг хийсэн байгаа. Энэ бичил мужлалын зураглалын дагуу авч ярих юм бол Дорнод аймгийн төв 5-6 баллын газар хөдлөлтийн байришилд байгаа бол Сүхбаатар аймгийн төв 5 6, Хэнтий аймгийн төв 6-7, Говьсүмбэр аймгийн төв 6-7, Дорноговь аймгийн төв 6, Дархан-Уул аймгийн төв 6-7, Дундговь аймгийн төв 7-8, Орхон аймгийн төв 7-8, Өвөрхангай аймгийн төв 7-8, Баянхонгор аймгийн төв 7-8,

Архангай аймгийн төв 7-8, Баян-Өлгий аймгийн төв 8-9, Улаанбаатар хотын 9 дүүргийн хувьд аваад үзэхэд Чингэлтэй дүүрэг 7-8, Хан-Уул дүүрэг 7-8, Баянзүрх дүүрэг 7-8, Сонгинохайрхан дүүрэг 8-9, Баянгол дүүрэг 7-8, Налайх дүүрэг 7-8, Багануур дүүрэг 7-8, Багахангай дүүргүүд 7-8 гэсэн ийм газар хөдлөлийн бүс нутагт байна. Монгол Улсын хэмжээнд бүх барилга 130 мянган ширхэг барилга байгаа гэж бид бүхэн тооллого хийсэн. Энэ барилга бол жижиг амбаараас эхлээд бүх барилгуудыг тоолсон гэж хэлж үзнэ. 130 мянган барилгаа хот, хөдөөгөөр нь ялгаад үзэх юм бол 117,910 буюу 90.7 хувь нь бол Улаанбаатар хотод, 12,090 буюу 9.3 хувь нь бол аймаг, орон нутагт байгаа. Энэ барилгуудыг цаг тооллоор 2 хувааж үзэх юм бол 2001 оноос өмнө баригдсан барилга бол дийлэнх буюу Улаанбаатар хотод баригдсан барилгын нийт 87.6 хувь буюу 103,289, хөдөө орон нутагт бол 62.8% хувь буюу 7,592 барилга баригдсан байна. Энэ барилгуудаас олон нийтийн барилгууд буюу сургууль, цэцэрлэг, эмнэлэг, соёлын, төвийн барилгууд бол 18,442 барилга байгаа. Үүнийг нийслэлийн хэмжээнд авч үзэх юм бол 9,821, аймгийн хэмжээнд авч үзэх юм бол 8,621 байгаа. Эндээс нэг зүйлийг онцгойлон 2 хувааж үзэх ёстой. 2002 оноос өмнө баригдсан барилгуудыг бид бүхэн онцолж үзэж байгаа. Энэ газар хөдлөлтийн нөхцөл дээр. Яагаад гэвэл 2002 онд газар хөдлөлтийн бүс нутагт барилга төлөвлөх норм ба дүрэм батлагдсан байдаг. Энэ норм ба дүрмийн дагуу 2002 оноос хойш бол барилгууд баригдаж байгаа. Энэ дээр бол бичил мужлалын зураглалууд нь бол тодорхой хийгдсэн. Газар хөдлөлтийн баллууд нь тодорхой хийгдсэн учраас 2002 оноос баригдсан барилгууд бол газар хөдлөлтөд харьцангуй гайгүй гэж үзэж байгаа. 2002 оноос өмнө барилгууд бол яг тухайн байришил дээр нарийвчилсан газар хөдлөлтийн баллыг тооцоогүй, ерөнхий байдлаар тооцсон учраас энэ барилгууд дээр бид бүхэн үнэлэлт, дүгнэлт хийх, шалгалт хийх, паспортжуулах ажлыг

зохион байгуулах нь зүйтэй байгаа юм. Ингээд Улаанбаатар хотод байгаа 1,844 барилгаас 944 барилга дээр бид бүхэн өнгөрсөн хугацаанд паспортжуулалд хийгдсэн. Паспортжуулалд хийгдсэн барилгууд дээр аваад үзэх юм бол газар хөдлөлтөд тэсвэртэй 206 барилга гарсан бол хүчитгэх шаардлагатай 195 барилга, газар хөдлөлтөд тэсвэргүй 543 барилга гарсан байгаа. Цаашидаа бол 900 барилгаа бол Улаанбаатар хотод паспортжуулалд хийх шаардлагатай. Аймаг орон нутгууд дээр бол паспортжуулалдын ажлууд бол бараг хийгдээгүй. Тодорхой аймгууд дээр цөөн тооны паспортжууллын ажлууд бол хийгдээд явж байгаа. Тэгэхдээ албан ёсоор дүгнэлт нь гараагүй байгаа. Дараагийн хуудсан дээр бол паспортжуулалтын мэдээллийг аваад үзэх юм бол байршил байршилаар нь гаргаж ирсэн. Жишээлэх юм бол Баянгол дүүрэг дээр жишээ авч үзье. Нийтдээ орон сууцын 118 барилга дээр паспортжуулалт хийгдэхэд газар хөдлөлтөд тэсвэртэй 43, хүчдэх шаардлагатай 18, газар хөдлөлтөд тэсвэргүй 57 гэдэг дүгнэлт гарсан. Олон нийтийн буюу сургууль цэцэрлэг эмнэлгийн барилга дээр бол газар хөдлөлтөд тэсвэртэй 2, хүчдэх шаардлагатай 5, газар хөдлөлтөд тэсвэргүй 30 гэсэн ийм дүн гарсан байна.

2 дугаар асуултын хүрээнд тайлбарлахад иргэн бүр өөрсдийнхөө ажиллаж амьдарч байгаа барилга, байгууламжийн талаар газар хөдлөлтөд тэсвэртэй эсэх талаар мэдээлэл авах боломжтой юу. Хууль, эрх зүйн орчин нь бүрдсэн үү гэдэг асуултад хариулахад, иргэн бүр өөрсдийнхөө амьдарч байгаа барилга, байгууламжийн талаар бол мэдээлэл авах боломжтой. Энийг бол Барилгын тухай хуулийн дагуу тухайн аймаг болон Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын байдаг Барилгын асуудал хариуцсан байгууллагуудаас бол энэ мэдээллийг авах боломжтой. Гэхдээ энэ мэдээлэл бол хязгаарлагдмал. Юу гэсэн үг вэ гэхээр паспортжуулалд хийгдсэн 944

барилга дээрээс л энэ мэдээллийг авах боломжтой. Үлдсэн барилгууд дээр энэ паспортжуулалд хийгдээгүй учраас мэдээлэл авах боломжгүй байгаа. Тэгээд энэ паспортжуулалтын ажлыг бол хуулийн дагуу барилгын тухай хуулийн 10.1.1, 1.2, 1.3 дээр бол аймаг, нийслэлийн Засаг даргын дэргэдэх Барилга, хот байгуулалтын газраас газрууд энэ паспортжуулалтын үйл ажиллагааг зохион байгуулна. Мөн хувь иргэд болон аж ахуйн нэгж байгууллагууд өөрсдийнхөө хүсэлтээр зардлаа гаргаад энэ паспортжуулалтын ажлыг хийж, барилгынхаа талаар мэдээлэл авах боломжтой байгаа.

Өнөөдрийн байдлаар бол зөвшөөрөлтэй хэд хэдэн байгууллагууд байдаг. Жишээлэх юм бол Нийслэлийн Хот байгуулалт, хөгжлийн газрын Барилга байгууламжийн чанарын хэлтэс байна. Реконстракин компани байна. Зураг төслийн 4.1 зөвшөөрөлтэй 999 аж ахуйн нэгжүүд энэ паспортжуулалтын үйл ажиллагааг зохион байгуулдаг байх нь байна. Паспортжуулалд хийгдэхэд бол төсөвт өртөг нь бол янз янз байдаг. Тухайн барилгынх нь хийцэл болон тоо хэмжээ, метр квадратаас хамаарна. Бид нар зүгээр ингээд урьдчилсан байдлаар 15 барилга дээр паспортжуулалтын ажил хийгдсэн. Төсвийг ингээд дундажлаад үзэхэд нэг барилга дээр дунджаар 10 сая төгрөгийн зардал гарахаар ийм тооцоо гарсан байгаа.

3 дугаар асуулт бол барилга, байгууламж барих зөвшөөрөл олгохоос эхлэн барьж байгуулах бүх шатын хяналт тавих, тохируулах. Энэ хяналтын ер нь тогтолцоо нь хэр сайн бэ гэдэг ийм асуулт байна. Ингээд агуулгаар нь аваад үзэх юм бол. Барилга зургийн шатаас эхлээд дуусах хүртэл төрөл бүрийн хяналт хариуцлагын тогтолцоо байдаг. Энэ хариуцлагын тогтолцоо дээр бол Барилгын тухай хууль, Төрийн хяналт, шалгалтын тухай хууль, Зөрчлийн тухай хууль, бусад эрх зүйн баримт бичгүүдээр бол тодорхойлогддог тогтолцоо байдаг.

Хяналт нь хаанаас явж байгаа вэ гэхээр тал тал бүр дээр хяналтууд явагддаг. Хувийн хэвшил нь ч хяналтаа тавьдаг, улсын байгууллага нь ч хяналтаа тавьдаг. Зургийн байгууллага зургаа зураад дуусахад тухайн норм ба дүрмийн дагуу зураг нь зурагдсан байна уу гэдгийг бол Барилгын хөгжлийн төв дээр төрийн байгууллага, мэргэжлийн экспертүүд гаргаж ирээд магадлалын дүгнэлт гаргаж тухайн зургийг баталгаажуулдаг. Энэ зургийн дагуу захиалагч болон гүйцэтгэгч байгууллага бол энэ барилга угсралтын ажлаа явуулдаг. Энэ дээр бол захиалагчийн хяналт хамгийн чухал. Захиалагч хяналтаа тавьдаг. Мөн зохиогч буюу зургийн авторууд хяналтаа тавьдаг. Барилга угсралтын ажил энэ хяналтын дагуу энэ зургийн дагуу баригдаж дуусаад, техникийн комисс ирж ажилладаг. Техникийн комисс дотор бол зургийн чиглэл чиглэлийн авторууд ирж тухайн барилга зургийн дагуу хийгдсэн байна уу, үгүй юү гэдэг хяналтаа тавиад баталгаажуулсны үндсэн дээр хамгийн сүүлд улсын комисс ирж ажилладаг. Энэ улсын комисс дээр бол төрийн байгууллагын гол гол чиглэлийн бүх мэргэжилтнүүд ирж, тухайн барилгыг байнгын ашиглалтад хүлээж авдаг. Энэ одоо хяналтыг зөрчсөн. Ямар нэгэн зургийн дагуу хийгдээгүй ч юм уу. Арга хэмжээн дээр ямар ямар арга хэмжээ авдаг вэ гэхээр төрөл бүрийн арга хэмжээ авдаг. Зөөлнөөс эхлээд хатуу хүртэл зөрчил арилгах зөвлөмж мэдэгдэл хүргүүлдэг, зөрчил арилгах албан шаардлага, дүгнэлт гаргадаг, торгуулийн арга хэмжээ авдаг, үйл ажиллагааг зогсоох арга хэмжээ авдаг, барилгын үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийг цуцлах арга хэмжээ авдаг. Бүр шаардлагатай бол иргэдийн аюулгүй байдалд харшаар нөлөөлж байна гэж үзэх юм бол барилгыг нураах хүртэл арга хэмжээнүүдийг хуульд тусгаад заасан байдаг.

4 дүгээр асуулт бол Барилгын тухай хууль, тогтоомж зөрчсөн

этгээдэд хариуцлага хүлээлгэсэн тухай статистик мэдээллийг сүүлийн 10 жилийн байдлаар асуусан байна. Энэ дээр бол бид бүхэн Мэргэжлийн хяналтын газартай ажиллаж байгаад сүүлийн 4 жилийн байдлаар энэ одоо мэдээг, тоог нэгтгэж гаргаж ирсэн. 2019-2022 оны 4 жилийн хугацаанд бол нийтдээ 18,514 иргэн хуулийн этгээд дээр бол хяналт шалгалт явагдсан. Үүнээс албан шаардлага 4922 өгөгдсөн, дүгнэлт 7132, зөвлөмж 4626 өгсөн бол иргэн, хуулийн этгээдэд тавьсан Зөрчлийн тухай хуулиар нийтдээ 1640 торгууль тавигдсан байна. Ингэснээр нийтдээ улсын төсөв дээр 1 тэрбум 901 сая 615 мянган төгрөг бол тавигдсан бол, бусад энэ шалгалтуудын хүрээнд бүх зөрчлүүдийг арилгах арга хэмжээ авсан байна.

Цаашидаа бид бүхэн энэ ажлуудаа идэвхтэй явуулах ёстой, үргэлжлүүлэх ёстой. Ингэхийн тулд 4 ажлыг бид нар хийж байгаа. Энийгээ сайжруулж ер нь бол илүү сайн хийх ёстой. Энэ бол бүгдээрээ мөнгө төгрөгтэй холбоотой төсөв мөнгө төгрөгтэй л холбоотой асуудлууд байгаа. Төсөв мөнгө төгрөгийн асуудал шийдэгдэх юм бол эдгээр асуудлууд бол хийгдэх боломжтой, хурдыг тодорхойлно гэж хэлж болно.

1 дүгээр ажил бол түрүүн би хэлсэн. 12 аймаг дээр бол бичил мужлалын зураглал хийгдсэн байгаа. Үлдсэн 9 аймаг дээр бол хийгдээгүй байгаа. Энэ 9 аймгийн бичил мужлалын зураглалыг хийх шаардлагатай байгаа. Энэ дээр 1.3 тэрбум төгрөг шаардлагатай. Энийг бид бүхэн Эдийн засаг, хөгжлийн яаманд бол саналаа хүргүүлсэн байгаа. Эндээс хариу хүлээж байгаа. Энэ төсөв мөнгө төгрөгийн асуудал шийдэгдэх юм бол энэ 9 аймаг дээр балл тодорхойлсон бичил мужлалын зураглал хийгдсэний дагуу бид бүхэн яг нарийн балл тооцсон барилгын зураг хийгдэж, үүний дагуу угсралтын ажил зохион байгуулах юм аа.

Хоёрдугаарх нь улсын хэмжээнд байгаа. 2002 оноос өмнө баригдсан олон нийтийн зориулалттай 6687 барилга, байгууламжийг паспортжуулах ажлыг зохион байгуулах шаардлагатай байгаа. Ингэж байж тухайн барилга газар хөдлөлтөд тэсвэртэй эсэх талаарх дүгнэлт эцсийн байдлаар гарч ирнэ. Энэ ажлыг хийхэд бол 66.8 тэрбум төгрөг хэрэгтэй байгаа. Үүнийг бид бүхэн Барилга, хот байгуулалтын яамны зүгээс бас байнгын төсөв дээр тавихаар санхүүгийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад бол хүсэлтээ тавьдаг. 2 дугаарт Барилгын тухай хуулиар бол энэ паспортжуулах үйл ажиллагааг бол аймаг болон нийслэлийн Засаг даргын Тамгын газар энийг зохион байгуулах ёстой. Яамны зүгээс бас тодорхой албан даалгавруудыг хүргүүлдэг. Хамгийн сүүлд 2023 оны 3 дугаар сарын 25-ны өдөр Даваасүрэн сайд энэ албан даалгавруудыг хүргүүлж, хэрэгжилтийг хангаж ажиллах ийм бичгүүд явуулсан байгаа.

Гуравдугаарх нь бол энэ хүчдэх шаардлагатай 195 барилга, байгууламжийн санхүүжилтийг шийдвэрлэж, хүчитгэлийн ажлыг эхэлбэл зохион байгуулах шаардлагатай байгаа. Энэ хүчитгэлийн ажлыг хийхэд бол Монгол бидний хувьд бол цоо шинэ асуудал байгаа учраас өнгөрсөн хугацаанд бид нар нэг ч барилгыг хүчитгэж чадаагүй байгаа. Гэхдээ энэ хүрээндээ олон улсын Жайка байгууллагатай хамтарч ажиллаж, эхний ээлжид бол 10 барилга дээр зураг төсөв санхүүг нь гаргаад, үүний дагуу хүчитгэлийн ажлыг зохион байгуулахаар ажиллаж байгаа. Тэгээд энэ шинэ ажил учраас холбогдох норм дүрэм эд нарыг бас батлах ажилтай. Ямар материалаар хүчитгэх юм, зургийн ажлыг нь яаж зохион байгуулах юм, яаж хийх вэ гэдэг норм ба дүрмийг бас боловсруулаад батлуулах ажлыг зохион байгуулж байгаа.

Дөрөвдүгээр асуудал бол нийслэлийн хэмжээнд газар хөдлөлтөд тэсвэргүй нураагаад барих шаардлагатай 543 барилга гэж тодорхойлсон. Үүнээс 144 барилга байгууламж нь бол олон нийтийн барилга байгаа. Сургууль, цэцэрлэг, эмнэлэг, соёлын төв байгаа. Эхний ээлжид энэ барилгуудыг яаралтай буулгаж шинээр барих ажлыг зохион байгуулах ёстой. Үүний хүрээнд бол өнгөрсөн хугацаанд 17 барилгыг буулгаж шинээр барьсан. Үлдсэн 127 барилгыг буулгаж шинээр барихад томсгосон төсвөөр 780 тэрбум төгрөг шаардлагатай байгаа. Энэ төсөв мөнгө төгрөгийн асуудлыг яаралтай шийдвэрлэж байж энэ аюулгүй байдлыг хангах ёстой байгаа.

Ингээд гишүүний тавьсан асуултад товчхон хариуллаа.

Б.Энх-Амгалан: Золбоо сайдад баярлалаа Гишүүнээс тавьсан асуултын хариуг сонсох өөр дэгтэй. Тэрийг бас уншиж танилцуулъя.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 111.1.2-т заасан Байнгын хорооны хуралдаанд асуултын хариуг холбогдох албан тушаалтан 3 минутаас илүүгүй хугацаанд танилцуулах бөгөөд гишүүд 3 минутаас илүүгүй хугацаанд асуулт асуух гэж заасан байна. Дэгийг танилцууллаа. Мэдээлэлтэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу. Бат-Эрдэнэ гишүүнээр тасаллаа. Дараа нь би бас нэмж асууя.

Одонтуяа гишүүний асуулт. Одонтуяа гишүүний микрофоныг өгье.

С.Одонтуяа: Тэгэхээр энэ бэлдсэн танилцуулга бол ойлгомжтой байна. Тэгээд хэд хэдэн зүйл асууя. Одоо ингээд манайд газар хөдлөлт болоод, энэ байшин барилга нураад яахад ер нь хэн хэн ямар асуудлыг нь хариуцах юм бэ. Жишээлэхэд Засгийн газар хариуцах юм уу эсвэл зөвшөөрөл өгсөн нийслэл

хариуцах юм уу, эсвэл төсөв хөрөнгө гээд Улсын Их Хурал хариуцах юм уу. Яг энэ хариуцлагыг хэн хүлээх вэ.

2 дугаарт энэ миний хамгийн санаа зовж байгаа юм бол энэ сая Туркт болсон газар хөдлөлт байгаа. Тэгэхээр Туркийг бол би бас барилгын чиглэлээр нэлээд өндөр хөгжилтэй орон гэж үздэг. Манайхан ч гэсэн барилгын материал энэ тэр Туркээс аваад. Гэтэл тэнд бол байдал ямар болов гэдгийг та нар харсан. Тэгэхээр ялангуяа энэ нийслэлийн асуудал бол намайг их зовоож байна. Нийслэлд маш олон орон сууцууд байгаа. Тэгэхээр 1 асуулт бол энэ манай социализмын үед баригдсан энэ угсармал орон сууцууд байгаа шүү дээ. 9 давхар 10 хэдэн давхар. Энэ орон сууцууд дээр ер нь энэ яг тэр голдуу Оросын Холбооны Улсад ийм барилгууд байгаа шүү дээ. Энэ газар хөдлөлтөд ер нь хэр тэсвэртэй байдаг юм бэ. Тэгэхээр энэ 2002 оноос өмнөх орон сууцуудыг та нар паспортжуулж амжаагүй гэж байна. Тэгэхээр энэ нь өөрөөсөө зураг төсөв нь хийгдэхдээ энэ бол газар хөдлөлтөд тэдэн балл тэсвэртэй гэсэн ийм зүйл байна уу гэдгийг ялангуяа энэ хуучны орон сууцууд дээр асуумаар байна.

2 дугаарт эхний ээлжид цэцэрлэг бол харьцангуй ингээд 2 давхар барилга байгаад байх шиг харагддаг. Эмнэлгийн асуудлууд дээр хамгийн ноцтой асуудлуудаас нь эхлээд паспортжуулаад ийм аянуудыг ингээд хийж болохгүй юу. Дээрээс нь шинээр баригдаж байгаа байгууллагууд өөрсдөө энэ зардлаа гаргаад хийдэг үү. Одоо бид нар нэг л ингээд улсаас л нэг мөнгө гаргана гээд байна шүү дээ. Тэгэхээр энэ хувийн хэвшлийн барьж байгаа барилгууд эсвэл улсын төсвийн хөрөнгөөр сүүлийн үед баригдаж байгаа барилгууд дээр яг энэ газар хөдлөлтийнх нь асуудлыг яаж шийдвэрлэдэг юм бэ. Энэ паспортжуулалт, өөрсдөө тухайн компани гаргаад хийдэг юм уу гэсэн ийм хэдэн асуулт эхлээд асууя даа.

Б.Энх-Амгалан: Асуултад хэн хариулах вэ. 3 номер Золбоо дэд сайд хариулъя.

Э.Золбоо: 2 дахь асуултад хариулъя. 1 дэх асуулт Гантулга дарга хариулах байх. 2002 оноос өмнө баригдсан барилгууд бол тухайн яг байршил дээр газар хөдлөлтийн баллыг нарийвчилж тооцоогүй, ерөнхий байдлаар тооцчихсон учраас эрсдэлтэй гэж үзэж байгаа юм. Энэ эрсдэлтэй гэдэг дүгнэлт ч гэсэн ер нь бидний сая 944 барилга дээр паспортжуулалд хийхэд гарч ирж байгаа юм. 20 хувь нь л газар хөдлөлтөд тэсвэртэй, үлдсэн 80 хувь нь бол тэсвэргүй гэдэг дүн гарч байгаа. Тэгээд таны саяын хэлдэг 40 мянгат, 50 мянгат эд нар бол 1960-1980 оны хооронд баригдсан. Тэгэхээр ер нь бол энэ бичил мужлалын зураглалууд нь бол тодорхой байгаагүй, ерөнхий байсан учраас ерөнхийдөө бол яг тухайн байршил дээр жишээлэх юм бол 7 баллын газар хөдлөлт явагдахад бол тэсвэрлэх боломжгүй ийм нөхцөл байдалд байгаа. Тийм учраас бид нар энэ 2002 оноос өмнө баригдсан бүх барилгууд дээр бол паспортжуулалд хийж нарийвчилсан дүгнэлт гаргах шаардлагатай байгаа. Паспортжуулалд хийгээд дүгнэлт гаргасан барилга, байгууламжууд дээр бол 2 хэлбэрээр явж байгаа. Улсын барилга байгууламжууд сургууль, цэцэрлэг, эмнэлгийг бол бид нар улсын төсөв дээр тавиад, дахин нураагаад, дахин барих ажлыг зохион байгуулж байгаа. Орон сууц таны хэлдэг орон сууцыг бол ашиглалтын шаардлага хангахгүй орон сууцуудыг бол хувийн хэвшлийнхэнтэй зохион байгуулж явж байгаа. Гэр хорооллын дахин төлөвлөлтийн хүрээнд. Тийм учраас хувийн хэвшлийнхэн бол тухайн барилгыг нураагаад шинээр барих ийм ажлуудыг бол зохион байгуулаад явж байгаа. Үүний хүрээнд жишээлээд ингээд хэлэх юм бол нийтдээ газар хөдлөлтөд тэсвэргүй, паспортжуулалд хийсэн 399 барилга дээрээ авч үзэх юм бол өнгөрсөн хугацаанд 61 барилгыг бол хувийн хэвшил

өөрсдөө буулгаад, барих энэ ажлыг бол зохион байгуулсан байгаа. Ингээд нэмэлт нарийн мэдээллүүдийг холбогдох хүмүүс өгөх байх. Яг одоо энэ газар хөдлөлт болоод асуудал гарахад аль аль байгууллагууд юуг хариуцах вэ гэдгийг манай Барилга, хот байгуулалтын яамны Барилга, бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Гантулга хариулна.

Б.Энх-Амгалан: Нэмээд Гантулга хариулъя. 3 номерын микрофон.

Д.Гантулга: Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе ээ. Газар хөдлөлт болоход яг газар хөдлөлтийн гамшигийн эрсдэл дээр яг гол шуурхай удирдлагын штаб маань Онцгой байдлын ерөнхий газар, Шадар сайдын эрхлэх асуудлын хүрээнд энэ явна. Газар хөдлөлд барилга, байгууламжид эвдрэл гэмтэл учирсан тохиолдолд Шадар сайдын 2021 оны тушаалаар батлагдсан барилга, байгууламжийг паспортжуулах, ашиглалтын гэрчилгээ олгох журмаар тухайн барилга, байгууламжийн яг нэвтрэх хэсэг дээр улаан, шар, ногоон гэрчилгээнүүдийг наах замаар тэр барилга байгууламжийг ашиглах боломжгүй гэдгийг эхний ээлжид тогтооно.

2 дугаарт тухайн барилга, байгууламжтай холбоотой бүх зураг төсөл, холбогдох бичиг, барим саналууд бол архивд байгаа. Тэгэхээр яг тухайн барилгын байгууламжаасаа эвдэрсэн тэр хийц эдлэлүүдээс нь шинжилгээ авах замаар материалдаа байсан юм уу нэгдүгээрт, 2 дугаарт зураг төсөлтэй байсан юм уу, 3 дугаарт барилгын ажлын гүйцэтгэл хэр чанартай байсан юм бэ гэдгийг, ямар этгээдүүд оролцсон бэ гэдгийг тэндээсээ тодорхойлоод аль дээр алдаа гарсан байна гэдгийг тодорхойлсны үндсэн дээр тэр хүмүүстээ бол хариуцлагаа тооцно гэж харж байгаа.

Э.Золбоо: Би энэ дээр нэг зүйл нэмж хэлэхэд ер нь энэ ингээд үзэхэд газар хөдлөлтийн асуудлыг аваад үзэхэд ер нь бол цаашидаа бид бүхэн энийг үнэхээр онцгой ач холбогдолтой гэж авч үзэх юм бол онцгой л арга хэмжээ авах ёстой юм байна лээ. Тэр нь юу вэ гэвэл энийг хариуцсан агентлаг ч юм уу байгуулах шаардлагатай юм байна гэж үзсэн. Яагаад гэвэл энэ газар хөдлөлтийн асуудал энд тэнд байгаа юм байна лээ. Нэг онцгой байдлын асуудал ч юм шиг, Барилга, хот байгуулалтын асуудал ч юм шиг. Нэг бол Шадар сайдын дэргэд байгаа Гамшигаас урьдчилан сэргийлэх үндэсний хорооны асуудал ч юм шиг. Ингээд энд тэндээ ингээд хаягдчихсан. Тэгээд энэ ажлууд өнгөрсөн хугацаанд бол удааширалтай явсан гэж харагдаад байгаа. Тэгэхээр 1 агентлаг байгуулаад, тэр агентлаг нь паспортжуулалтын ажлаа бүгдийг нь зохион байгуулдаг, төсөв мөнгө төгрөгөө хөөцөлддөг энэ паспортжуулалтын дагуу дүгнэлтийн дагуу энэ хүчитгэх ажлыг зохион байгуулдаг. Бусад барилгуудыг дахин буулгаад шинээр барих эд нар ажил хариуцсан эзэнтэй байхгүй бол энэ асуудал бол ингээд нэг жилийн өмнө нэг Байнгын хороон дээр яригдсан. Үндэсний хороон дээр яригдсан. Ингээд л яригдаад л өнгөрөөд л яваад байгаа юм байна лээ. Яг ингээд хурдаа аваад үзэх юм бол хүчин чадал нь бид нарт байхгүй. Жишээ нь нийслэлийн байгууллага энэ паспортжуулалтын ажлыг зохион байгуулдаг. Яг ингээд уулзаад үзэхэд бол сардаа 3 барилгыг л паспортжуулах ийм хүний нөөцтэй юм байна лээ. Тэгээд жилдээ 36 барилгыг паспортжуулна. Ганцхан хийж байгаа байгууллага. Тэгээд ингээд яваад үзэх юм бол энэ бол цаашидаа энэ дээр Их хурлын гишүүд ер нь анхаараад ийм арга хэмжээ авахгүй бол энэ бол ингээд л яваад байх магадлалтай санагдсан.

Б.Энх-Амгалан: За ойлголоо. Ц.Тулга Хотын ерөнхий архитектур бөгөөд Хот байгуулалт, хөгжлийн газрын дарга. Та 1 номерын микрофон

дээр очоод суучих. Нэг дээр сууж байгаад хариулчих. Энэ ажлын хэсэгт байж байгаад энэ хуралд ирээгүй хүмүүсийг протоколд тэмдэглэж аваарай. Баян-Эрдэнэ гэж онцгой байдлын газрын хүн байна. Дамдинсүрэн гэж хүн байна. Загдсамбар энэ тэр гээд энэ ирдэггүй нөхрүүдийг бол бичээд авчхаарай. Их Хуралд хүндэтгэлтэй хандана шүү нөхөд. 1 номерын микрофон хариулъя.

Ц.Тулга: Одонтуяа гишүүний асуултад хариулъя. Угсармал барилгын тухай бас онцлоод асууж байна. Тэгэхээр Улаанбаатар хотод 2002 оноос өмнө баригдсан нийтийн зориулалттай орон сууцын 672 барилга дээр газар хөдлөлтөд тэсвэрлэх чадварын үнэлгээ хийсэн байгаа. Үүнээс 55 барилга нь бол угсармал барилга дээр хийгдсэн. Угсармал барилгын тухайд гэх юм бол газар хөдлөлтөд тэсвэрлэх чадварын үнэлгээгээр зайлиггүй хүчитгэх шаардлагатай гэсэн ийм дүгнэлт гарсан байгаа. Харьцангуй 1970 оноос өмнө баригдсан тоосгон барилгуудын хувьд бол газар хөдлөлтөд тэсвэргүй гэдэг үнэлгээ гараад, одоо ашиглалтын шаардлага хангахгүй барилгыг буулган, дахин төлөвлөн барилгажуулах төсөл бол хэрэгжээд явж байгаа. Эмнэлгийн тухайд бол 2002 оноос өмнө баригдсан төрийн өмчийн эмнэлэг, сургууль, цэцэрлэг, урлаг, соёлын байгууллагын барилга, албан конторын барилга гэх мэтчилэн нийтдээ 272 барилга дээр газар хөдлөлтөд тэсвэрлэх чадварын үнэлгээ хийсэн. Үүнээс бол 144 барилга нь бол тэсвэргүй гэж гарсан байгаа. Эндээсээ эмнэлгийн барилгыг онцолж үзэх юм бол 25 барилга дээр үнэлгээ хийгдсэн байна. Үнэлгээ хийж паспортжуулсан. Эндээс 3 эмнэлэг бол тэсвэртэй, 9 эмнэлгийг бол хүчитгэх шаардлагатай, 13 эмнэлгийг бол тэсвэргүй учраас буулгаад, дахин төлөвлөн барилгажуулах шаардлагатай гэсэн ийм үнэлгээ дүгнэлт гарсан байна. Зардлын тухайд гэх юм бол одоогоор Шадар сайдын баталсан зөвлөл байгаа. Зөвлөлийн дүрэм байгаа. Үүнд бол

төрийн өмчийн сургууль, цэцэрлэг, эмнэлгийн барилгууд дээр зайлиггүй төсвөөс хөрөнгө зарцуулж газар хөдлөлтөд тэсвэрлэх чадварын үнэлгээ хийгдэж байгаа. Орон сууцын барилгын тухайд бол 2019 онд гарсан дүрмээр тухайн орон сууцыг эзэмшигч, өмчлөгч нар зардлыг гаргана гэсэн ийм заалттай байсан. Энэ заалт гарснаас хойш бол орон сууцын барилга нийтийн зориулалттай орон сууцын барилга дээр иргэд нь бол тухайн газар хөдлөлтөд тэсвэрлэх чадварын үнэлгээ хийлгэх хөрөнгө гаргах чадваргүйн улмаас энэ ажил 2 жилийн хугацаанд бас зогсонги байдалд орсон. Үүний дараа бол Шадар сайдаас дүрэмд бол өөрчлөлт оруулаад 2002 оноос өмнө баригдсан нийтийн зориулалттай орон сууцын барилга дээр зайлиггүй улсын төсвийн хөрөнгөөр газар хөдлөлтөд тэсвэрлэх чадварын үнэлгээг хийх юм байна гэдэг ийм байдлаар өөрчлөлт ороод энэ ажил хэрэгжээд явж байгаа. Өнгөрсөн жил бол бид 250 сая төгрөгийн төсвийн хөрөнгө оруулалт суугаад нийтдээ.../минут дуусав/

Б.Энх-Амгалан: Гүйцээгээд хариулчихъя. 1 номерын микрофоныг. Товчхон хариулаарай.

Ц.Тулга: Энэ жил бол 150 сая төгрөг бол төсөвт суусан байгаа. Бид нар 18 барилга дээр газар хөдлөлтөд тэсвэрлэх чадварын үнэлгээ хийх гээд жагсаалтаа батлуулсан. Одоо худалдан авах ажиллагаа зарлагдаад явж байгаа.

Б.Энх-Амгалан: Баярлалаа. Цогтбаатар гишүүн асуулт асууя. Цогтбаатар гишүүний микрофоныг өгье.

Д.Цогтбаатар: Баярлалаа. Одонтуяа гишүүн маш чухал асуулт, асуулга тавьсан байна аа. Тэгээд энэ дээр хэдэн зүйл асуучихмаар байна.

1 дүгээрт 2015 онд Барилгын сайд байхдаа би яг энэ асуудлуудыг ер нь шийдэх үүднээс Монгол Улс евро стандарт руу шууд шилжээд MNS рүү шилжүүлэлгүйгээр шууд Евро

стандартуудыг хэрэглэдэг болъё. Тэгэхдээ барилгын салбарт зардал огцом нэмэгдчих учраас эхлэхдээ үе шаттайгаар хийе гээд хотын төлөвлөлтийг энэ евро стандартаар хийе гээд бараг 900 гээд евро стандартыг шууд нэвтрүүлэх эрх зүйн үндэс бүх юмыг нь боловсруулж өгөөд, тэгээд нэвтрүүлэх шийдвэрийг нь гаргаж өгөөд уг нь явж байсан юм. Тэгээд тэрийг буцаачихсан юм байна лээ л дээ. Одоо энэ евро стандарт руу шилжүүлэх процесс ер нь юу болж байгаа вэ. Тэгэхгүй бол бид нар өнөөдрийг болтол MNS гэдэг маань *snip* стандарт дээр суурилоод явж байгаа. Эндээсээ бид нар гараагүй л яваад байгаа. Тэгэхээр араас нь гарч ирэх асуудал өөрийн эрхгүй евро стандарттай байсан бол таны асуулт бараг гарахааргүй байхгүй юу.

2-т Байнгын хороон даргаас нэг юм асуумаар байна. Энэ чинь нээлттэй хэлэлцүүлэх асуудал мөн үү, биш үү? Яагаад гэвэл сая энд яригдаж байгаа тоонууд та нар наад салбарынхаа зах зээлд яаж нөлөөлөх мэдээллүүд ярьж байна. Энэ чинь одоо зөндөө хүмүүсийн үл хөдлөх хөрөнгийг үнэгүй болгоод хаячхаж байна шүү дээ. Тэгэхлээр энийг ингээд бид нар ил явуулж болох уу. Энэ чинь иргэдийнхээ эрх ашгийг, хөрөнгийг хамгаалж байгаа алхам болж байгаа байхгүй юу. Тэгэхгүй өнөө маргаашигүй шууд шийдэж чадахгүй байж энийг ингээд яриад явах асуудал мөн үү, үгүй юу.

2-т энэ Сүхбаатар дүүргийн барилгуудын асуудлыг сая Одонтуяа гишүүн асуулаа. 40, 50 мянгатын тэнд бол гол хийх ёстой юм юу вэ гэхээр энэ жижигхэн газрууд дээр л барилга барьсаар байна. Одоо энэ хотын удирдлага энэ дээр хариулмаар байна. Энийг хэзээ зогсоох вэ.

2-т энд харин дахин төлөвлөлт хийж тэр маш хүнд нөхцөлд амьдарч байгаа хүмүүст шинэ тэр барилгыг барих, барилгажуулах асуудал дээр та

нар хэр анхаарч, бодлого гаргаж байгаа вэ гэсэн ийм 3 л асуулт байна даа.

Б.Энх-Амгалан: 1 дүгээрт Одонтуяа гишүүнээс ирэхдээ нууцын зэрэглэлтэй буюу хаалттай хийх санал ирээгүй. Нээлттэй байгаа асуулт нь. Тэгээд нээлттэй хэлэлцэж байгаа юм. Тэгээд та нар хариулт дээрээ бас анхаараад явна биз дээ. Хэн асуултад хариулах вэ. 1 номерын микрофон. 3 номерын микрофоныг өгөөдөхье.

Д.Гантулга: Цогтбаатар гишүүний асуултад хариулъя. 2015 оноос ер нь барилгын салбар энэ евро норм стандартад шилжих ийм гол үндсэн чиглэл батлаад бариад явж байгаа. Ер нь энийг татаж авсан гэдэг маань бас нэг талаараа арай жаахан өрөөсгөл л дөө. Яагаад гэхээр евро норм норматив баримт бичгийн үндсэн тогтолцоо маань хамгийн түрүүнд техникийн зохицуулалт гэдэг бичиг баримт гараад, техникийн зохицуулалтаасаа салбарлаад стандартууд гардаг ийм тогтолцоотой. Тийм учраас барилгын салбар маань яг энэ тал дээр 2015 оноос хойш ажиллаад сая энэ 3 сарын 15-нд Засгийн газрын хуралдаанаар барилга байгууламжийн аюулгүй байдлын техникийн зохицуулалт, дээрээс нь барилга байгууламжийн галын аюулгүй байдлын техникийн зохицуулалт гэсэн ийм 2 бичиг баримтыг хэлэлцүүлж баталсан байгаа. Одоо яг энэ маань нөгөө олон улсын түвшиндээ очихоороо тэр Европын норм нормативын тогтолцооны техникийн зохицуулалттайгаа ингээд шийдээд ирчхэж байгаа гэсэн үг. Тэгээд үүний дараа бид нар стандартуудаа Европын, нөгөө гадаад улсын энэ түвшинд хүргэнэ гэж байгаа. Сүүлийн үеийн мэдээгээр Стандартын газраас илүү тодорхой мэдээлэл өгөх байх. Миний санаж байгаагаар нэг нийт стандартын 55 хувь нь олон улсын түвшинд хүрсэн ийм стандартууд энэ дотроосоо 40 хэдэн хувь нь болохоор Евро стандарт ISO стандарт болсон гэсэн ийм мэдээлэлтэй

байгаа. 1 дүгээр асуултын хувьд ингээж хариуллаа. Баярлалаа.

Б.Энх-Амгалан: Нийслэлээс асуусан. 1 номер Тулга дарга хариулъя.

Ц.Тулга: Хотын төвийн барилгажсан хэсгүүд дээр нэмж барилгын зөвшөөрөл олгох асуудлын талаар асууж байна. Тэгээд Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хууль батлагдаад 2022 оны 1 сарын 1-ээс хэрэгжээд эхэлсэн байгаа. Энэ хуулийн б дугаар зүйл дээр бол нийслэлийн нутаг дэвсгэрт хүн амын нягтрал ихэссэн бүсэд шинээр газар олгох, барилга барих зөвшөөрөл олгохыг хориглосон ийм заалттай. Одоо бид нар нийслэлийн нутаг дэвсгэрт хүн амын нягтрал ихэссэн ямар ямар бүсүүд байна вэ гэдгийг тодорхойлж гаргасан байгаа. Энийг Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хуралд өргөн барьж хэлэлцүүлж батлуулахаар бэлтгэл ажил хангагдсан байгаа. Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлсэн. 2018 онд Нийслэлийн Засаг даргаас нийслэлийн хэмжээнд III байршил дээр хот тосгоны төлөвлөлт барилгажилтын норм дүрэмд заасан хүн амын нягтрал хэтэрсэн III байршилыг бол тодорхойлсон байдаг. Энийг бол зайлшгүй бид нар Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоолоор баталгаажуулаад цаашдаа нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн хэрэгжилтийг хангаад ингээд ажиллахаар бэлтгэл ажил хангагдаад явж байгаа.

Дахин төлөвлөлтийн асуудлууд маань ер нь бол барилгын газар хөдлөлт тэсвэрлэх чадварын үнэлгээ хийгээд энэ дээр тэсвэргүй гэж гарсан барилгууд 944 байгаа гээд ерөнхий тоон дүнгээрээ бид нар бол танилцуулж явж байгаа. Тухайлсан яг аль аль барилгууд вэ гэдгийг олон нийтэд бол мэдээлэхгүй байгаа. Энэ дээр бол Нийслэлийн мэргэжлийн хяналтын улсын ахлах байцаагчийн ашиглалтыг хориглосон шийдвэр гарсан

барилгууд дээр бид нар ашиглалтын шаардлага хангахгүй барилгыг буулгах төсөл хэрэгжүүлэхийн тулд зайлшгүй сонгон шалгаруулалт явж байгаа учраас эдгээр барилгууд бол олон нийтэд нээлттэйгээр мэдээлэгдээд энэ төслүүд бол хэрэгжээд явдаг. Үндэсний аюулгүй байдлын зөвлөмж дээр бол мөн адил анх тухайн орон сууц өмчилж байгаа иргэний өмчийн асуудал яригддаг учраас энэ бол нууцын зэрэглэлтэй байх ёстой гэсэн ийм шаардлага байсан одоо бол энэ шаардлага байхгүй байгаа. Гэхдээ бид нар бүх барилгуудыг тийм тийм барилгууд гэдэг байдлаар бол олон нийтэд зарлахгүй байгаа.

Б.Энх-Амгалан: Бат-Эрдэнэ гишүүн асуулт асууя. Бат-Эрдэнэ гишүүний микрофоныг өгье.

Б.Бат-Эрдэнэ: Баярлалаа. Би 2 зүйл хэлье. Ер нь Улаанбаатар хотын төлөвлөлт их алдагдсан ийм л зүйл л дээ. 2000-аад оны өмнөөс тэгээд тухайн үед бол энэ Улаанбаатар хотынхонтой бид нар ч бас холбоотой байсан. Улаанбаатар хотын дарга Энэбиш гуай чинь манай Самбо бөхийн холбооны ерөнхийлөгч. Бид нарыг хүүхэд байхаас л одоо тэмцээн уралдаанд авч явдаг ийм байсан. Тэгээд энэ хотын улсууд 1990-ээд оны эхээр бол хотын одоо холбогдох эрх бүхий хүмүүст бас энэ талаар санал онол солилцож л байсан юм л даа. Тухайлах юм бол Улаанбаатар хотынхоо салхины дээр байгаа энэ гэр хорооллуудаа зүүн тийш нь гаргахдаа Багахангай, Баян сум хүртэл гаргаж болох тухай асуудал, цаашилах юм бол энэ Улаанбаатар хотын шинэ төвлөрөл, шинэ хот байгуулагатай холбоотой ийм асуудлууд тавьдаг л байсан. Тэгээд харин бүр түүнээс тэс эсрэгээрээ Улаанбаатар хотын дэд бүтцийн нягтралыг сайжруулна гэдэг энэ нэрийн дор ингээд Улаанбаатар хотыг өнөөдрийн ийм дүр зурагтай л болгочихсон байхгүй юу даа. Тэгээд энэ бодлогоо та нар маань үнэлэлт, дүгнэлт өгдөг үү. Энийгээ ер нь өөрчлөх талаар ямар шийдвэр гаргах юм

бэ. Тэгээд манайд ер нь батлагдсан хууль, дүрэм журам, стандарт ийм юмыг бол зүгээр дээгүүр нь эрх мэдэлтэй хүмүүс ч тэр, жирийн хүмүүс ч адилхан тэр дээгүүр чөлөөтэй гишгэдэг, алхдаг учраас тэгээд үр дагавар нь ийм л өнөөдрийн дүр зураг л гараад байна л даа. Одоо энэ бол тун хүнд ийм нөхцөлтэй л байна. Засгийн гарын хурлаар өглөө болгон 30 минутыг Улаанбаатар хотын түгжрэлтэй холбоотой мэдээлэл, авах арга хэмжээний чиглэлээр яриад ингээд л анхаарал тавиад байдаг. Гэтэл ингээд суурь шалтгаан нь 1990 оноос хойш ингээд айхтар хүндрүүлчихсэн учраас энийг арилгахад л хүндрэлтэй ийм л зүйл харагдаад байгаа юм. Тэгээд энэ дээр тодорхой зүйл хэлэх бололцоо байх уу.

Дараагийнх нь юм бол түрүүн Золбоо сайдад дурдагдаад өнгөрнө лээ. Энэ газар хөдлөлтэй холбоотой ийм асуудлаа хариуцсан Шадар сайдын дэргэд байдаг юм уу, бүр бие даасан статустай агентлаг байгуулж хариуцуулах юм уу эсвэл онцгой эрхтэй ийм алба, нэгж байгуулж байж энийг дагнаж хариуцахгүй бол энэ чинь ингээд бид нарын байж байгаа байдал юм шүү дээ. Энд тэнд нэг ойчин тэгээд 1 цаг үеийн байдалтай нэг удаа уулздаг, ярьдаг, нэг мэдээлэл солилцдог, танилцуулга хийдэг. Нэг тодорхой шийдвэр гарсан ч тэр шийдвэр нь амьдралд бодитойгоор хэрэгждэггүй. Ийм байдлаасаа болоод маш нөгөө ниргэсэн хойно нь хашихирна гэдэг ишг хүнд байдал руу орох вий. Энэ дээр Байнгын хороо бүр тусгайлан.../минут дуусав/

Б.Энх-Амгалан: Нийслэлийн Засаг даргын Эдийн засаг, дэд бүтцийн асуудал хариуцсан 1 дүгээр орлогч Сандагсүрэн дарга хариулъя. 1 номерын микрофон. Маш тодорхой асуулт асуусан шүү.

Ц.Тулга: Гэр хороололтой холбоотой асуудал бас хөндөгдөж байна. Тэгээд нийслэлийн хэмжээнд бол хот байгуулалтын үндсэн 2 төсөл хэрэгжиж байгаа. Хот, суурин газрыг дахин

хөгжүүлэх тухай хуулийн дагуу гэр хорооллыг дахин төлөвлөн барилгажуулах, гэр хорооллын газар шинэчлэн зохион байгуулах, ашиглалтын шаардлага хангахгүй барилгыг буулган дахин төлөвлөх гэсэн ийм 3 төсөл хэрэгжиж байгаа. Энэ бол Барилга, хот байгуулалтын сайдын баталсан журмын дагуу хэрэгждэг. Улаанбаатар хотын гэр хорооллын бүс нутаг дээр нийтдээ 25 байршлын 87 хэсэгчилсэн талбай дээр гэр хорооллын дахин төлөвлөлтийг хэрэгжүүлэхээр байршилыг тодорхойлоод эхнээсээ төсөл хэрэгжүүлэгч нар шалгараад ингээд явж байгаа. Зарим байршил дээр бол харьцангуй хүндрэлтэй асуудлууд үүсэж байгаа дэд бүтцийн асуудлууд үүсэж байгаа учраас зогсонги байдалд орсон. Тэгэхдээ энэ жил бид нар эдгээр ажлыг бүгдийг нь нягталж үзээд хамгийн хэрэгжүүлж болохоор 4 байршил дээрээ энэ ажлаа идэвхтэй явуулъя, дээр нь дэд бүтцийнх нь асуудлыг бол зайлиггүй хамгийн эхний ээлжид шийдвэрлэе гэдэг байдлаар Эрчим хүчний яам, Барилга, хот байгуулалтын яам, Нийслэл хамтраад гэр хорооллын дахин төлөвлөлтийн ажлыг цааш явуулахаар төлөвлөж байгаа. Улаанбаатар хотыг 2040 он хүртэл хөгжүүлэх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө дээр мөн Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх стратегийг боловсруулах талаар тусгаад, энийг бол 2006 онд анх боловсруулсан байсан энэ стратеги төлөвлөгөөгөө зайлиггүй шинэчлээд явах нь зүйтэй байна гэдэг ийм шийдэлтэйгээр ингээд явж байна.

Б.Энх-Амгалан: Нэмж хариулах юм уу. Түрүүнд санал хэлчихсэн. Та нэмж асуух уу. Бат-Эрдэнэ гишүүн 1 минут тодруулъя.

Б.Бат-Эрдэнэ: Би түрүүн цаг багтаагүй учраас асууя. Энэ дахин төлөвлөлттэй холбоотой юм дээрээ анхаарахгүй бол та нар маань ингээд л яг л хуучин бахь байдгаараа яваад байх юм даа. Энэ хойшоо 100 айл, Дэнжийн 1000

энэ тэр рүү төлөвлөж байгаа, тэнд барьж байгаа байшингаа та бүхэн маань хараарай даа. Ямар ч төлөвлөлт байхгүй. Зүгээр л дур дураараа аваачаад тавьчихсан. Тэгээд гаднаа дахиад л зогсоол байхгүй, талбай байхгүй. Тэгээд л хэт өндөр барилгажилтын ийм юмнууд хийгээд л тавьчихсан байх юм. Тэгээд л энэ юм чинь ингээд цаашаагаа үргэлжлэх юм бол яах юм. Ер нь манай нийслэл, манай Улаанбаатар хотын төлөвлөлт шиг ийм одоо энэ бол 1990 оноос хойш л зах замбараагаа алдчихсан л ингээд ирэх юм шүү дээ. Үгүй ээ, энэ чинь хойно, урд, хойшоо энэ уулын орой дээр очоод газар өгөөд, тэрийг нь араас нь дагаад замыг нь бариад, тэгээд уулын орой дээр усан сан байгуулаад, тэгээд цахилгааныг нь татаж өгөөд тэгээд тэнд нь сургууль, цэцэрлэг, эмнэлэг барина гээд, үгүй ээ, ийм юм гэж ер нь яа яаж байх вэ дээ. Нүглийн нүдийг гурилаар хуурна гэдэг шиг л юм хийгээд.../минут дуусав/

Б.Энх-Амгалан: Дэлгэрсайхан гишүүн асуултаа асууя.

Б.Дэлгэрсайхан: Энэ их цаг үеэ олсон хэрэгтэй ийм мэдээлэл орж ирж байна. Манай Их Хурлын дэд дарга Одонтуяагийн санаачилгаар. Тэгээд энэ газар хөдлөлт жилд яг Монгол Улсад энэ газар хөдлөлт хамгийн дээд тал нь хэдэн балл байдаг юм, хэдэн удаа хөдөлдөг юм, энэ нь аль аль бүсэд их идэвхтэй байдаг юм гэдгийг 1 дүгээрт асуумаар байна.

2 дугаарт хүн амын төвлөрөл тэр дундаа Улаанбаатар сая бас ярьчих шиг боллоо. Зүгээр энэ барилгын чанарт ер нь хэр анхаарал тавьж байна. Ер нь шинээр барьж байгаа, хуучин барилгууд бол ойлгомжтой. Зүгээр шинээр барьж байгаа барилга ингээд л дөрвөлжин каркас цутгаад л, баахан болсон, болоогүй блокоор дүүргээд л хөөсөнцөр наадаг нэг энэ юунаасаа хэзээ гарах вэ барилгын дэд сайд аа. Тэгэхгүй одоо чинь бол юм хөгжөөд аль ч улс орон бай ер нь сүүлийн үед манай дотооддоо ч гэсэн барьж байгаа барилга чинь бүрэн

цутгамал руугаа явж байна шүү дээ. Тэгээд энийгээ стандарт болгосон уу. Цаашидаа нэг ийм мөнгө хэмнэж байна гэдэг юм уу, юу гэдэг юм 2-ын хооронд ийм муу барилга бариад, тэрийгээ их үнэтэй зараад ч гэдэг юм уу, ашиг олохын тулд юу ч хамаагүй хог цуглуулаад барьдаг ч асуудал байна. Тэгээд энийг ер нь яаж шийдэх юм бэ цаашидаа гэдэг нэг ийм 2 асуудал асууя.

Б.Энх-Амгалан: 3 номерын микрофон Золбоо дэд сайд хариулъя. Газар хөдлөлтийг нь газар хөдлөлтийг нь хэн хариулах вэ. Онцгой байдлын ерөнхий газар хариулъя. Эхлээд Золбоо дэд сайд хариулаадах.

Э.Золбоо: Дэлгэрсайхан гишүүний асуултад хариулъя. Энэ барилгууд бол гол төлөв манай Монгол Улсад бол төмөр бетонон каркас хэлбэрээр явж байгаа. Тэгээд таны хэлдэг каркасаа цутгаад тэгээд блокоор өрөөд, хөөсөнцрөө тавиад дулаалаад ийм нэг хэлбэрээр явж байгаа. Нөгөө хэлбэрүүд нь бол бүрэн цутгамал байдлаар явж байгаа. Тэгээд энийг бол бас яг манай яамны зүгээс бүрэн цутгамал нь илүү чанартай гээд, төмөр бетонон каркасыг ер нь бол хориглоё гэсэн яг тийм юм руу бол бодсон тийм бодлого бол байхгүй байгаа. Тэгээд энэ чинь нөгөө сонголтоор явж байгаа учраас. Тэгээд материалууд эд нар нь бол аль болох л тэгээд л эдийн засгийн нөхцөл байдал дээр төмөр бетонон бүрэн цутгамал барилга барих юм бол метр квадратын өртөг нь өндөр болно. Тэгээд манай нөгөө худалдан авах чадвар ямар байгаа билээ. Тэгээд л төмөр бетонон каркас таны хэлдэг нөгөө блок өрөөд л тэгээд л хөөсөнцөр дулаалга хийгээд л явдаг. Тэгэхдээ энэ бол яг бусад улсуудад хэрэглэгддэггүй тийм жишиг бол биш. Бусад улс орнуудад бол хэрэглэгддээд явдаг. Европ бол бараг тэр чигээрээ нөгөө хөөсөнцрөөр тортой замаскаа татаад, будаад явдаг. Гэхдээ манайд бол эндээ бол чанарын асуудлууд бол байдаг. Ялангуяа урдаас орж ирж байгаа барилгын материалууд дээр бол

чанарын асуудал яригддаг. Яагаад гэвэл яг нөгөө төв лаборатори байдаггүй Замын-Үүд дээр. Энэ лаборатори байдаггүй учраас яг нөгөө чанарыг нь үзэж чаддаггүй тохирлын гэрчилгээ дээр нь үндэслэж материалууд орж ирдэг. Тэр дээр нь тэр орж ирж байгаа материалууд бол чанаргүй байх иргэд хохирдог эд нар асуудлууд байдаг. Тэгээд энэ чиглэлээр бол бид нар ер нь барилгыг чанартай болгоё гэвэл барилгын материалыг л чанартай болгох ёстой. Энэ хүрээндээ лаборатори барьж байгаа. Замын-Үүд дээр лаборатори барьж байгаа. Та мэдэж байгаа байх. 500 метр квадрат барилга барьж байгаа. Энэ барилгын ажил бол энэ жил дуусна. Тэгээд нийтдээ яг иргэдийг хохироодог 8 нэр төрөл дээр барилгын материалыг шалгадаг, сорилт шинжилгээний лаборатори барьж байгаа. Тэгэхээр Замын-Үүдээр орж ирж байгаа барилгын материалуудыг шалгаад, тэр цахилгааны утас, сангийн кабель бусад хохироогоод байдаг юмнуудыг бол шалгах боломжтой болно. Алтанбулагийн боомт дээр Гаалийн ерөнхий газрын лаборатори баригдаж байгаа. Энэ дээр тоног төхөөрөмжүүд суурилуулахаар бид нар ярьсан. Энэ 2 боомт дээрээ барилгын материалыг шалгаад оруулж ирэх юм бол ер нь нийт орж ирж байгаа импортын барилгын материалын 90 хувь нь бол энүүгээр орж ирдэг юм байна лээ. Тийм учраас бид нар барилгын материал дээрээ онцгой анхаарч байгаа. Тэгээд бусад норм дүрэм, стандартуудыг ингээд байнга цаг тухай бүрд нь сайжруулаад явж байгаа.

Б.Энх-Амгалан: Тэр газар хөдлөлттэй холбоотойг нь хэн хариулах вэ. 1 номерын микрофон. Нэр, албан тушаалаа хэлээд хариулаарай.

М.Өлзийбат: Өлзийбат газар хөдлөлт судлах салбарын дарга. Ерөнхийдөө Монгол Улсын нутаг дэвсгэрийн хэмжээнд бол жилдээ 60-аад мянган газар хөдлөлт бүртгэгддэг дундаж тоо. Түүнээс яг хүнд мэдрэгдэх

хэмжээний газар хөдлөлт бол 50-60 болоод байгаа жил болгон. Яг зарим идэвхжил өндөртэй жилдээ бол 150 мянга орчим газар хөдлөлтийг бид нар бүртгэж авч байдаг. Газар хөдлөлийн идэвхжилийн хувьд бол ерөнхийдөө баруун аймгууд маань нэлээн аюултай бүсэд багтаж явдаг. Ер нь 1900-1980 оны хооронд манай улсын хэмжээнд бол тийм асар хүчтэй газар хөдлөлт 4 удаа тохиолдсон байдаг. Энэ 4 нь бол Завхан, Увс, Баян-Өлгий, Ховд, Говь-Алтайн нутаг дэвсгэрүүд дээр тохиолдсон байдаг юм. Ерөнхийдөө бид нарын сүүлийн үед яриад байгаа нь Улаанбаатарын асуудал байгаа. Улаанбаатар хот маань энэ 2005 оныг хүртэл бол ер нь газар хөдлөлийн идэвхжилийн хувьд дунд зэргийн, аюулын хувьд бол харьцангуй гайгүй гэж тооцогдож явдаг байсан. 2005 оноос эхлээд бид нарын ажиглалтын материалд юу ажиглагдсан гэхээр газар хөдлөлийн идэвхжил өндөрсөж байгаа нь харагдсан. Тэгээд газар хөдлөлт гэдэг бол бид нар зүгээр нэг хот юм уу, дүүргийн нутаг дэвсгэрээр авч үздэггүй. Яг өөрийнх нь болоод байгаа тэр зүй тогтол стракчур гээд том бүс нутгаар нь авч үздэг. Энэ утгаараа 150 километрийн радиус дотор Улаанбаатар орчимд болж байгаа дунд хэмжээний газар хөдлөлтийн тоо ч гэсэн бас сүүлийн хэдэн жил огцом өссөн. Энэ жил гэхэд л Борнуурын сангийн аж ахуйн тэнд магнитуд нь 5 дахин өссөн газар хөдлөлт болж байх жишээтэй. Тэгээд энэ дээр судалгаа хийгээд үзэхэд яг Улаанбаатар хот аюул үзүүлж болох хэмжээний тийм 6 голомт байна гэж тогтоосон байдаг юм. Энэ 6 голомт маань яг Улаанбаатар хотоосоо бид нар зайг нь аваад үзвэл 50-80 километрийн зайтай. Тэгээд ингээд л газруудын голомт маань хот руугаа ойртох тусам л ер нь учрах гамшигийн хэмжээ нь бол маш өндөр болдог. Тэгээд 2017 онд бид нарын хийгдсэн судалгаа нөгөө Улаанбаатар хотын бичил мужлалын зураг гээд сая ярьсан. Үүгээр яг Улаанбаатарт үүсэж болох голомтынх

нь яг жишээлбэл энэ голомтууд дээр газар хөдөллөө гэхэд үүсээж болох баллынх нь хэмжээ бол 8-10 баллаар тогтоогдсон байдаг юм. Нэг иймэрхүү нөхцөл байдал үүсчхээд л байж байгаа. Яг Улаанбаатарт бол 2005 оноос өмнө яг энэ 150 километрийн бүс нутагт жилдээ 200-аад газар хөдлөлт болдог байсан. Энэ тоо маань бол одоо 10 дахин өсчихсөн. 2 мянга орчим газар хөдлөлт тохиолддог болчихоод байгаа юм. 2 дахь том нөхцөл нь тэр дунд зэргийн хүчтэй газар хөдлөлт гэдэг маань Улаанбаатар.../минут дуусав/

Б.Энх-Амгалан: Ойлголоо. Би нэг асуулт асуугаадахъя. 2010-2022 оны хооронд нийт 416,838 удаа газар хөдөлж. 2022 оны эхний 9 сарын байдлаар 813 удаа газар хөдөлсөн байна. Тэгээд энд чинь барилгын нийтийн орон сууцын зориулалтын 377 барилгыг ашиглахыг хориглочихсон. Тэгсэн ч гэсэн тэнд нь хүн сууж байгаа гээд тийм мэдээлэл явж байдаг. Сая хотынхны хэлж байгаагаар бол 25 байршилд 87 төсөл арга хэмжээг хэрэгжүүлж байгаа. Улаанбаатар хотыг 2040 он хүртэл хөгжүүлэх төлөвлөгөө дээрээ 111 байршил дээр нягтрал хэтэрсэн газрууд байгаа тэндээ хийж байна гээд байдаг. Гэтэл энэ газар хөдлөлийн чинь судалгаа энэ Нагоягийн их сургуулийн судалгааны дүнгээр чинь бол Улаанбаатарт ер нь барилга барьж болох юм уу. Яг энэ Туул голын чинь эрэг дагуу энэ дунд гол дотор барьчихсан барилга энэ тэрээ яах юм бэ. Энэ 543 барилга бол газар хөдлөлтөд тэсвэргүй гэж та нарын өгсөн тоон дээр байна шүү дээ. Тэгээд ингээд цааш нь үргэлжлүүлээд бариад байж болох юм уу. Сандагаа дарга аа. Энэ дээр нэг хариулаадхаач наадах чинь 25 байршилд 87 төсөл хэрэгжүүлнэ гэдэг чинь энэ дотроо дахиад л барьж байна л гэсэн үг шүү дээ. Нягтралтай газраа. Тэгээд Улаанбаатар чинь өөрөө энэ жил болгон энэ аюул чинь нэмэгдээд байхад ингээд бид нар тойруулаад шавар овоолоод байж болох юм уу. Тэгээд энэ олон барилгуудаа яах вэ. 543 барилга байна

шүү дээ. Нэг хариулаадхаач. 1 номерын микрофон.

Ж.Сандагсүрэн: Стандартын дагуу Улаанбаатар хотод баригдаж байгаа барилгууд дээр 8 баллын газар хөдлөлтөд тэсвэртэйгээр зураг төсөв бүх юм нь батлагдаад ингээд энэ дагуу зөвшөөрөл нь олгогдоод барилга, байшин баригддаг. Барилга, байшин баригдах үед түрүүн 2 гишүүний асуулт дээр дурдагдана лээ. Хяналт ер нь яг хэн тавиад, ямар хариуцлага одоо хүлээх юм бэ гэдэг. Ер нь бол 4 төрлийн хяналт тавигдаж байшин барилга баригдаж байна.

1 дүгээрт зохиогчийн хяналт, 2-т нь бол захиалагчийн хяналт, гүйцэтгэгчийн хяналт болон хөндлөнгийн хяналт. Хөндлөнгийн хяналт дээр төрийн хууль тогтоомжийн дагуу Төрийн хяналт шалгалтын тухай хууль, Зөрчлийн тухай хуулийн дагуу төрийн байгууллагуудаас хяналт тавьж явдаг. Бусад үндсэн 3 төрлийн хяналт дээр бол барилгын гүйцэтгэгч, захиалагч, зохиогчийн хяналтууд бол нэлээн өндөр түвшинд ингэж тавигдаж ингэж явдаг юм.

Барилга байшин баригдах зөвшөөрөл авах энэ үйл явц бол одоо хууль тогтоомжийн дагуу зөвшөөрөгдсөн газар нөгөө хотыг хөгжүүлэх төлөвлөгөө болон хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний дагуу холбогдох зөвшөөрөл аваад ингээд барилга байшин баригдаж явдаг. Ямар нэгэн байдлаар хотод байшин барихыг шууд хориглох ч юм уу ийм шийдвэрүүд одоогоороо бол гараагүй байгаа. Үе үед асуудал шийдвэрлэхийн тулд тодорхой хугацаагаар барилга байгууламжийн зөвшөөрлийг өгөх, тодорхой бүсүүдэд барилга байгууламжийг барихыг хориглох ийм шийдвэрүүдийг үе үеийн хотын удирдлагууд бол гаргаж ингэж ирсэн. Энэ нь голдуу нягтралтай холбоотойгоор ингэж шийдвэрүүдийг гаргаж ингэж явсан. Тэр голын эрэг

дагуу болон бусад нөхцөлүүдэд бол яг л тэр тухайн орчин нөхцөлд нь байшин барилгын тэсвэртэй байдлыг хянаж шалгаад тодорхой зөвшөөрлүүдийг нь олгоод явсан ийм нөхцөл байдалтай байгаа.

Б.Энх-Амгалан: Та нар маань тэгээд тийм мундаг олон шалгалтууд ороод л тийм хөндлөнгийн хяналт тавиад байгаа юм бол яагаад энэ барилгыг чинь тоо өсөөд байгаа юм. Тэр газар хөдлөлт тэсвэргүй барилга чинь 543, хүчитгэх шаардлагатай нь 195 гээд л. Тэгээд Нийслэлийн Засаг даргын 5 удаагийн захирамжаар нийт 14 барилгыг дахин төлөвлөх барилгажуулах ажлыг НОСК хийж байна гээд л ингээд л гараад байдаг. Тэгээд тэр гол дотор чинь бариад байж болж байгаа юм уу. Барилгууд чинь тэгээд тэр газар хөдлөлтийн тэсвэр хангасан барилга болж чадаж байгаа юм уу.

Ж.Сандагсүрэн: Улаанбаатар хотын хэмжээнд нийтийн болон орон сууцын зориулалттай нийтийн эзэмшлийн зориулалттай 30 мянган барилга байшин байгаа юм. Саяын яригддаг газар хөдлөлтийн тэсвэргүй яригдаад байгаа паспортжуулалт шаардлагатай барилгууд нь бол 2002 оноос өмнө нь баригдсан нөгөө стандартын батлагдаагүй ийм үед баригдсан ийм барилгууд дээр энэ асуудлууд яригдаж тэр газар хөдлөл нь тэсвэргүй нөхцөл байдал яригдаж байгаа юм. Түүнээс хойш баригдсан барилгууд дээр бол нөгөө стандарт нь шинэчлэгдчихсэн энэ үед нөгөө хяналт шалгалтын нөхцөл байдал нь өөр болчихсон учраас энэ барилгууд дээр бол асуудал өөрөөр тавигдаж байгаа юм. Манай Тулга дарга тэр голын эрэг дагуу барилгын зөвшөөрөл бусад асуудлаар та нэмэлт хариулах нь зөв байх.

Б.Энх-Амгалан: Тулга дарга 1 номерын микрофонд сууж байгаад хариулчих.

Ц.Тулга: Улаанбаатар хотын газар хөдлөлтийн бичил мужлалын зургаар бол голын эрэг дагуу хэсэг маань хамгийн өндөр буюу 8 баллын газар хөдлөлтийн муж байгаа. Ингээд голын эрэг дагуу Улаанбаатар хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд орон сууцын болон олон нийтийн барилга барихаар төлөвлөгдсөн газрууд дээр бол барилга байгууламжийн зөвшөөрөл олгогдож байгаа. Тухайн газар хөдлөлтийн 8 баллын мужид баригдах барилга маань анхнаасаа зураг төсөл хийгдэхдээ тухайн балд тэсвэртэй байхаар зураг төсөл нь хийгдээд, үүний дагуу баригдаад барилга баригдах явцад бол захиалагч, зохиогч, зураг төсөл зохиогч, мөн хөндлөнгийн хяналт, төрийн хяналт шалгалт гэсэн ийм олон хяналт шалгалтын дагуу эдгээр барилгууд баригдаж байгаа учраас бол газар хөдлөлтөд тэсвэртэй гэж ингэж тооцох ёстой байгаа.

Б.Энх-Амгалан: Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Мэдээлэлтэй холбогдуулан үг хэлэх гишүүд байна уу. Нэрээ өгнө үү. Дэлгэрсайхан, Цогтбаатар гишүүнээр тасаллаа. Дэлгэрсайхан гишүүн үгээ хэлье.

Б.Дэлгэрсайхан: Энэ хот мэдэж байгаа юм уу үгүй юм уу? Тэр энэ Туулыг дагаад нөгөө Ривер Гарденаас баруун тийш бургасыг нь ингээд л тайраад л хороолол бариад байх юм. Тэр бургас дууслаа шүү. Тэр ямар хороолол билээ. Яг тэр Туулын наад талд баруун, зүүн тийшээ тэлээд байна шүү дээ. Өдөр ирэх тусам тэр хамаг бургас нь дууслаа. Та нар өнөөдөр Туул ингээд тасарчихсан байна шүү дээ. Та нар мэдэж байгаа юу. Тэгээд яах вэ газар худалдаж болдог л байх л даа. Би заавал тэрний эзэн хэн бэ энэ тэр гээд байх юм алга. Ер нь энэ бас Туул голынхоо эрэг дагуу бургас тайрч байгаа юмаа жоохон болихгүй бол ер нь бол бид нар голын дагуу ч яах вэ хөдөлбөл сайн л биз дээ. Тэгээд тэр их өндөр барилга бариад их мөнгө олоод байгаа хүмүүс тэгээд арыг нь даах юм байгаа

биз. Тийм биз дээ. Тэгээд энийг та нар хот бодохгүй юм уу. Одоо энэ чинь зардаг, зардаг гэхэд юм чинь бас нэг хэмжээ хязгаартай байх ёстой шүү дээ. Тэр хэдэн бургасыг бол яг нүдэн дээр тайрчихлаа шүү дээ. Тэнд нэг зөгийн аж ахуй байсан бараг тэр рүү ойртоод оччихсон байна лээ. Чи мэдэж байгаа байх. Тэр чинь нэлээн их бургастай шүү. Одоо тэр зөгийн аж ахуй гээд нэг амбаар байсан. Тэр ч бараг алга болох юм шиг байгаа юм. Нэг өдөр харахад. Тэгээд энийг та нар бас бодолцооч ээ.

2 дугаарт сая Золбоо сайд ярилаа. Блокоор барьж болно л гээд байгаа юм. Энэ цэцэрлэг, сургуулийг бол тэгж болохгүй санагдаж байгаа юм. Цэцэрлэг, сургуулийг бол харин танайх стандарт батлаад бүрэн цутгамлаар хийхгүй бол яах вэ тэр орон сууц бол хямд өртөгтэй байх үүднээс энэ бол ойлгож байна. Цэцэрлэг, сургуулийг бол бүрэн цутгамлаар хийхгүй бол энэ бол нэг өдөр аюул ирэхэд бол тоглоом биш шүү. Ялангуяа энэ дээр бас та бүгд ер нь цаашидаа юу бодож байгаа юм. Энэ бол ёстой хамгийн ноцтой зүйл шүү. Тэгэхээр цэцэрлэг, сургуулийнхаа стандартыг бол жоохон өөрчлөөд юу гэдэг юм бүрэн цутгамлаар байх ёстой ч гэдэг юм уу энэ чинь бас бид нар үр хүүхдээ бодох ёстой шүү дээ. Тийм л 2 ц хэлэх юм. За баярлалаа.

Б.Энх-Амгалан: Баярлалаа
Цогтбаатар гишүүн үгээ хэлье.

Д.Цогтбаатар: Энэ сонсгол ингээд зүгээр нэг сонсгол болоод өнгөрөх ёсгүй. Тэгэхээр Одонтуяа гишүүн өөрөө бас анхаарч байгаад Золбоо сайд чухал санаа хэлж байна. Тэгэхээр яг энийг хариуцсан нэг агентлаг байх ёстой юу, үгүй юу гэдэг асуудал ярьж байна шүү дээ. Одоо ингээд л аягүй бол шинэ орон тоо энээ тэрээ гэдэг асуудал гарч магадгүй учраас энэ санаа нь бол зөв байхгүй юу. Эзэнтэй байх ёстой. Тэгэхээр энийг сайдынх нь доор юм уу та бүр өөрөө анхаарч байгаад эсвэл Ерөнхий

сайдын доор юм уу энэ байгаа хариуцсан энэ чинь яах аргагүй бас салбар салбараараа хариуцсан мэргэжилтнүүд нь тэр газрууддаа байж байгаад тэгэх ч ёстой байгаа байх. Тэгэхээр энийг нэгтгэсэн тогтмол хуралдаж байдаг, асуудлаа хэлэлцэж байдаг нэг зөвлөл ч юм уу, хороо ч юм уу, байнгын ажиллагаатай ажлын хэсгийг ч юм уу, Ерөнхий сайдын доор юм уу, сайдынх нь доор байгуулж өгөх нь зөв юм байна. Энэ дээр та нар бас нэг юмыг анхаараарай. Зөвхөн юу газар хөдлөлтийн асуудал биш. Одоо энэ галын аюулын асуудал байна. Энэ дээр эрх биш энэ ордонд байгаа энэ сигнализация бол ажиллах байлгүй дээ. Айлуудад байгаа тэр сигнализация чинь хүмүүс нэгэнт тавьчихсан болохлоор ажиллана гэж бодоод байгаа юм. Та нар бүр энийг тусгайлан шалгаад айлууд дээр энэ чинь ажиллаж байна уу, үгүй юу. Энэ бол аягүй чухал шүү бас. Тэгэхээр энэ дээр та нар онцгойлон анхаарч энэ дээрээ бас арга хэмжээ авах нь зөв байх гэж бодож байна.

Тэгээд тэр евро стандартын тухай өөрөө түрүүн нэг ийм юм хэлчихлээ. Бас ингэж ярих нь учир дутагдалтай ч гэх шиг. Би өөрөө тэрийг чинь хариуцаад, шийдвэрийг нь гаргаад больсныг нь мэдээд байгаа хүн сууж байна шүү дээ. Өөрийн чинь өгч байгаа хариулт бол яг манайд өгдөг хүнд суртлын хариулт нь байхгүй юу. Яг тэгж явдаг би тэрийг чинь өөрөө сайн мэднэ. Миний яриад байгаа юу гэхээр тэр евро стандартаар ингээд шинжлэх ухааны технологийн шинэчлэлийг бүгдийг нь гүйцээд, энийг бүгдийг нь Монгол руу орчуулаад процедураараа яваад нэвтрүүлнэ гэвэл хэзээ ч угаасаа гүйцэхгүй юм байна лээ. Тийм учраас ийм юмнуудыг шууд тэр хэл дээр нь шууд тэрүүгээр нь аваад хэрэглэх тухай би яриад байгаа байхгүй юу. Тэгэхгүй бол аягүй олон юман дээр. Одоо эм дээр ч гэсэн Харвони орж ирэх гэж байхад би санаж байна. Иргэдэд энэ нь өнөөдөр хэрэгтэй байхад манайх тэрийг нь судлаад өшөө ингээд хэрэглэгдэж болох

нь уу, үгүй юу тогтооно гээд хүнд хүлээх цаг байхгүй байгаа байхгүй юу. Тэгэхэд баруунд бүх шатаараа судлагдаад хүнд энэ нь хэрэгтэй байна, үйлчилж байна гэдэг нь тогтоогдсон юм дээр хурдавчилсан аль ч юм дээр fast rack гэж байдаг юм. Тийм процедураар аваад нэвтрүүлдэг л байх ёстой байхгүй юу. Би тэрийг л ярьсан юм. Тэгэхээр би юу ярьж байгаагаа бол аягүй сайн өөрөө ойлгож ярьж байгаа байхгүй юу. Баярлалаа.

Б.Энх-Амгалан: Тэгээд энэ хуралдааны дэгтэй холбоотойгоор хэрвээ Одонтуяа гишүүн нөгөө асуулт тавьсан гишүүн өөрөө Байнгын хороонд хүсэлтээ ирүүлбэл засагт бас чиглэл өгөх тогтоол энэ тэр гарах юмнууд бас байж болох юм билээ. Тэрийг та тэгээд өөрөө бодно биз. Тэгээд одоо бол дээгийнхээ дагуу Одонтуяа гишүүн 5 минут үг хэлнэ. Одонтуяа гишүүний микрофоныг өгье.

С.Одонтуяа: Баярлалаа тэгээд бас Байнгын хороон дээр энэ мэдээллийг хуваарьт оруулж өгсөн Энх-Амгалан даргад баярлалаа. Миний гол ярих гээд байгаа асуудал бол юу гэдэг юм. Хэн нэгнийг буруутгах гээд л ингээд байгаа биш. Ерөөсөө энэ чинь хүний эрхийн амьд явах эрхийн асуудал. Үндэсний аюулгүй байдлын асуудал байгаа. Тэгэхээр энэ дээр бид нар яг юу хийх юм бэ гэдэг өөрөө их чухал. Та нар энэ мэдээлэл бол бас сайн бэлдсэн байна. Би бол нэлээд юм ойлгочихлоо. Яг хэдэн барилга нь гээд. Тэгээд энэ мэдээллийг аваад миний бодож орж ирснээс илүү ерөнхийдөө бүр аюултай байдал хүндэрч байгаа байхгүй юу. Эрсдэл улам ихсэж байгаа юм байна. Би бүр арай ч энийг бас ийм гэж бодоогүй дутуу ойлгож байсан. Тэгэхээр өмнө нь би санаж байна. Улсын Их Хурал дээр Элбэгдорж ерөнхийлөгч бас хаалттай хуралдаан дээр ярихад бүгд л сэртхийж л байсан. Тэгээд л тэрнээс хойш бид нар бол нэг их ахисан юм харагдахгүй л байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ дээр сая Цогтбаатар гишүүний хэлдгээр бид нар нэг юм ямар ч байсан энэ чиглэлийг хариуцсан нэгж

байгуулах ёстой. Хамаа алга. Нэг зөвлөл ч юм уу, хороо ч юм уу. Энэ нь бол нэг жилийн хугацаатай ч байж болно шүү дээ. Нэг жилийн хугацаанд ингээд энэ байгууллагууд нь ирээд хуралддаг, заавал орон тооны зөвлөл байхгүй байж болно. Орон тооны бус зөвлөл ч байх юм уу. Энийг нэг Энх-Амгалан дарга аа бүгдээрээ ярьж байгаад энэ ажлын хэсгийг нэг байгуулъя. Сайжруулах ажлын хэсэг байгуулна гэвэл хамаа алга. Би энийг нь ахлаад бас энэ байгууллагуудтай ажиллаад ингээд яг энэ газар хөдлөлттэй холбоотой асуудлыг бол бид нар ингэж хаяж болохгүй байна. Та нар мэдэж байгаа байх Гаити Улс бас газар хөдлөлтөөс болоод л одоо хэдэн жилийн өмнө ч билээ 10 жилийн өмнө ч билүү одоо хүртэл ерөөсөө тэр юу нь арилахгүй байгаа шүү дээ. Бүр улсаараа сүйрчихсэн байхгүй юу. Зөвхөн энэ газар хөдлөлтөөс болоод. Тийм учраас энэ дээр бол бид нар зүгээр нэг хаяж болохгүй. Ялангуяа энэ орон сууцын энэ хуучин угсармал орон сууцнууд дээр хэд хэдэн байршилд хэд хэдэн газар ингээд газар хөдлөлтийг нь хэмжээд биш ээ одоо юуг нь тэр тэсвэртэйг нь тогтоогоод бид нар ядаж ийм хэд хэдэн дүгнэлттэй л болчихмоор байна. Тийм дүгнэлтүүд бол гарчихсан байгаа бол ядаж би нөгөө нэг бүрчлэн бүгдийг нь шалгадаггүй юм гэхэд 3 дугаар хорооллын 12 давхрыг ийм байдаг юм байна. Ийм ийм балл-д ингэдэг юм байна гээд, ингэж ингэж хүчитгэх хэрэгтэй байдаг юм байна ч гэдэг юм уу ингээд нэг ийм зүйлүүд гарах ёстой. Бүх юмыг төсөв рүү бас чихмээргүй байна. Одоо бүгдээрээ ярьж байгаад ямар арга байж болох вэ. Үгүй ээ, үүгээрээ төсөл бичээд гадаадын тусламжууд байдаг шүү дээ. Манай нийслэлд зөндөө төсөл хэрэгжүүлдэг. Тэгэхээр энэ төслүүд рүүгээ хандах ямар боломж байна. Энэ зүйлийг олохгүй бол зүгээр ингээд төсөв хараад суугаад бид нар бол бас явахгүй ээ. Тэгэхээр энэ төсөв дээр ч гэсэн юм оруулъя. Гэхдээ 100 хувь бол шийдэж чадахгүй байна.

Дээрээс нь энэ ард иргэдэд мэдээлэл өгөх, газар хөдлөлтийн талаар мэдээлэл өгөх. Манайх чинь нийслэлийн онцгой байдлын маш том гоё сургалтын төвтэй болсон шүү дээ. Тэгэхээр энэ сургалтын төв чинь тэгж 100 хувь хүмүүстэй байж ажиллаж байна уу. Би нөгөө дүүргийн дарга байхдаа л дүүргийнхээ хүүхдүүдийг л тэнд ингээд оруулаад л хичээл заалгаад байдаг байсан. Одоо тэгээд тийм юм хийгдэж байна уу, үгүй юу. Би зүгээр нөгөө нэг ингээд хэвлэл мэдээллээр тэр нь ингээд харагдахгүй болохоор би зүгээр хийгдэхгүй байгаа юм уу л гэж бодож байна. Энэ дээр бид нар ажиллах ёстой. Хэвлэл мэдээллийн байгууллагуудаар ч гэсэн контентуудыг бэлдэж, энэ газар хөдлөлтийн аюултай холбоотой зүйлийг ярих хэрэгтэй. Тэгээд ер нь мэдээж 5 минутад энэ бүх зүйлийг би ярьж амжихгүй. Тэгэхээр энэ дээр ажлын хэсэг эхлээд байгуулаад чиглэл өгөөд ингээд ажилламаар байна. Энэ чинь үнэхээр аюултай байдал. Сая Туркт юу болов. Турк бол зөвхөн тэр балл нь хүнд, их учраас нурсан юм биш шүү дээ. 2 өөр хот 2 өөр байна гэдэг чинь бид нарын бас эндээс дүгнэлт хийх л асуудал. Тэгээд сүүлд нь баахан барилга нураад, баахан хүн амь эрсэдчихсэн үед бид нар хэчнээн орилоод яах вэ дээ. Тийм учраас одоо ер нь энэ чиглэлүүдийг бол хариуцаж хиймээр байна гэдгийг хэлье. Тэгээд Энх-Амгалан дарга энэ дээр Улсын Их Хурлын тогтоолын төсөл байх ёстой юм уу, ажлын хэсэг байгуулаад энэ чиглэлээр ажиллах ажлын хэсгийг хэдэн сарын хугацаатай байгуулах ёстой юм уу энэ аргачлалаа бодоод хэлье. Та бүгд бас саналаа хэлнэ биз. Тийм ээ, одоо яг үнэндээ хэлэхэд дахиад л нэг агентлаг ч юм уу, нэг байнгын ажиллагаатай гэхээр бас дахиад л нэг юм болно. Тэгэхээр одоо орон тооны бус зөвлөл юм уу, нэг хороо юм уу ажиллуулаад энийг ингээд гол нь энэ байгууллагуудын үйл ажиллагааг хооронд нь уялдуулаад, энэ ажил ямар ч байсан л энэ аюулыг сөрөнд авах чадвартай хэмжээнд л очих ёстой л гэж.

Б.Энх-Амгалан: Баярлалаа манай Их Хурлын Тамгын газрын Хяналт шалгалтын хэлтсийнхэн байгаа. Та нар маань Одонтуяа гишүүнтэй цуг энэ асуудлаа боловсруулаад Байнгын хороонд танилцуулаадхаарай. Тэгж байгаад ажлын хэсэг байгуулагдах ёстой юу эсвэл тогтоолоор үүрэг өгөгдөх ёстой юу нэг тийм юмнуудыг хийхгүй бол энэ зүгээр ингээд нэг сонсоод өнгөрөх асуудал бол биш болчхоод байгаа юм.

Улаанбаатар нь удахгүй усны асуудал хүнд болох нь. Газар хөдлөлт чинь өөрөө ийм байдалтай байна. Тэгээд усныхаа эх үүсвэр рүү шахаад суурьшлын бүс болгочихсон ийм ийм юмнууд байгаа учраас ер нь бол энэ барилгатай холбоотой асуудлаа дахиж нэг анхаарахгүй бол болохгүй байгаа юм. Золбоо сайд нэг юу яагаадхаач. 3 номерын микрофон.

Э.Золбоо: Газар хөдлөлтийн гамшигийн эрсдэлээс сэргийлэх үндэсний хороо гээд бас байгаа. Шадар сайд ахлаад байнгын ажиллагаатай. Тэгэхээр бид нар нөгөө ажлын хэсэг байгуулахаар тэдний үйл ажиллагаатай бараг давхцах болов уу яах бол. Тэгээд хот дээр ч гэсэн комисс байгаа. Энэ ингээд салбар бүрийн төлөөллүүд орсон, яг хариуцсан байгууллага хойноос нь хөөцөлдөж гүйдэг хүн, байгууллага байхгүй болохоор энэ хүрээнд л ер нь ажил аягүй удааширчхаад байгаа л гэж би хараад байгаа юм. Тэгэхээр одоо хийх ажил маш их байгаа. Яагаад гэвэл паспортжуулалт хийх ажил байна. Үүний мөнгө төгрөгийг олох ажил байна. Гаднын байгууллагуудтай уулзах эд нар гээд. Тэр паспортжуулалтын үүднээс хүчитгэх ажлууд байна. Энэ хүчитгэх ажлууд ерөөсөө хийгдэхгүй ингээд яваад байгаа. Тэгээд л нөгөө буулгаад барих энэ тэр гээд л хийх ажлууд маш их байгаа.

Б.Энх-Амгалан: Ойлголоо. Энийг тэгээд Засгийн газарт чиглэл болгосон тогтоолын төсөл болгоод оруулах нь бараг зөв байх. Энд одоо тэгээд Үндсэн

хууль хэлэлцээд ирэхээр бас нэлээн юманд нь явахгүй болчихоод ирэх байх.

Ингээд Улсын Их Хурлын гишүүн С.Одонтуяагаас Барилга, хот байгуулалтын сайд Ц.Даваасүрэнд хандаж “Монгол Улсад баригдсан болон баригдаж буй орон сууц, барилга байгууламж нь газар хөдлөлттэй тэсвэртэй эсэх” талаар тавьсан асуултын хариуг сонсож дууслаа.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул өнөөдрийн хуралдаан өндөрлөснийг мэдэгдье. Хуралдаанд идэвхтэй оролцсон Улсын Их Хурлын гишүүддээ болон Ажлын хэсэгт баярлалаа. Хуралдаан өндөрлөлөө.

13.52 цаг.

Дууны бичлэгээс буулгасан:

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

Э.СУВД-ЭРДЭНЭ